



# СУРГУУЛИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СЭДЭГ АНЫСАН

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



---

# СУРГУУЛИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

---

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот

2021 он

# СУРГУУЛИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Судлаачдын багийн ахлагч Б.Батжаргал  
Гишүүд Г.Ганцэцэг  
Ч.Цогзолмаа  
Б.Батчимэг  
Д.Бумчин

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

---

**ӨМНӨХ ҮГ**

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

## ГАРЧИГ

|   |    |
|---|----|
| Өмнөх үг .....  | 3  |
| Товчилсон үгийн тайлбар .....   | 4  |
| Оршил/Суурь мэдээлэл .....  | 12 |
| Үнэлгээний зорилго, зорилт .....  | 13 |
| Хөндлөнгийн үнэлгээний хүлээгдэж байгаа үр дүн.....   | 13 |
| Хөндлөнгийн үнэлгээний асуулт.....  | 13 |
| Арга зүй .....  | 14 |
| Судалгааны хэрэглэгдэхүүн.....  | 16 |
| Мэдээлэлд хийсэн шинжилгээ.....   | 18 |
| Хөндлөнгийн үнэлгээний хязгаарлагдмал тал ба бэрхшээл.....  | 18 |
| БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЖ<br>ҮНЭЛЭХ ҮЙЛ ЯВЦАД ОЛОН ТАЛЫН ОРОЛЦООГ ХАНГАСАН ЭСЭХ..... | 19 |
| ХХБ СУРГУУЛИЙН БУСАД БАРИМТ БИЧГИЙН УЯЛДАА .....  | 30 |
| ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ .....  | 33 |
| Сэтгэл ханамж.....  | 47 |
| ДОТУУР БАЙР .....   | 49 |
| Дүгнэлт .....   | 62 |
| Зөвлөмж.....  | 63 |
| Хавсралт.....   | 66 |

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

---

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

|                 |  |
|-----------------|--|
| ЕБС             | Ерөнхий боловсролын сургууль                                     |
| БСШУ            | Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан                                   |
| БШУГ            | Боловсрол, шинжлэх ухааны газар                                  |
| БЕГ             | Боловсролын Ерөнхий Газар  |
| БХ              | Боловсролын хэлтэс   |
| “БНБТ!”<br>ИНҮЭ | “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний Нийгмийн Үндэсний<br>Эвсэл |
| НҮБ             | Нэгдсэн Үндэстний Байгууллага                                    |
| СӨУБ            | Суралцагчдын өөрийн удирдлагын байгууллага                       |
| СЭЭБХ           | Сургуулийн эцэг эх, багшийн Холбоо                               |
| ХХБ             | Хүүхэд хамгааллын бодлого  |

## ХҮСНЭГТ

|            |  |    |
|------------|--|----|
| Хүснэгт 1. | Хөндлөнгийн үнэлгээний эх олонлог .....  | 10 |
| Хүснэгт 2. | Хөндлөнгийн үнэлгээний сургуулийн түүвэр .....   | 11 |
| Хүснэгт 3. | Сургуулиас авсан асуулгын болон ярилцлагын судалгааны<br>түүвэр .....  | 12 |
| Хүснэгт 4. | Сургуулийн ХХБ-ын үйл явцад оролцогч, сонирхогч, үр шим<br>хүртэгч тал ба судалгааны арга, хэрэглэгдэхүүн, өгөгдөл<br>цуглуулах төлөвлөгөө ..... | 12 |
| Хүснэгт 5. | Сургуульд хийх өөрчлөлтийн талаар суралцагчдын хариулт<br>/анги, хүйсээр/ .....  | 41 |

## ГРАФИК

|            |   |    |
|------------|---|----|
| График 1.  | Танай хүүхдийн сургуульд ХХБ байдаг уу? .....   | 16 |
| График 2.  | ХХБ боловсруулахад таны саналыг авсан уу? .....   | 17 |
| График 3.  | Хэрэв тийм бол ямар хэлбэрээр санал авсан бэ? .....   | 17 |
| График 4.  | ХХБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөөний талаарх багш нарын хариулт .....  | 19 |
| График 5.  | Сургуулийн орчинд суралцагчдад учирч болох эрсдэлийг үнэлэхэд оролцсон эсэх .....   | 19 |
| График 6.  | Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрхэн танилцуулсан бэ? .....   | 22 |
| График 7.  | ХХБ-ыг албан ёсоор танилцуулсан эсэх.....   | 22 |
| График 8.  | Танилцуулсан бодлогыг ойлгосон эсэх .....   | 23 |
| График 9.  | Сургуулийн орчинд суралцагчдад учирч болох эрсдэлийг багасгах ажилд оролцож байсан эсэх .....                               | 23 |
| График 10. | ХХБ-ын хэрэгжилтийн тайланг танилцуулдаг эсэх .....   | 24 |
| График 11. | Эрүүл аюулгүй орчныг тодорхойлсон нь .....  | 29 |
| График 12. | Эрүүл аюулгүй орчны талаарх ойлголт .....   | 30 |
| График 13. | “Үл хайхрах” гэдгийг тодорхойлсон нь .....  | 31 |
| График 14. | Үл хайхрах ойлголт .....  | 32 |
| График 15. | Дарамт гэдгийг тодорхойлсон нь.....   | 32 |
| График 16. | Дарамтын талаарх ойлголт .....  | 33 |
| График 17. | Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангасан эсэх (1) .....                                      | 34 |
| График 18. | Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангасан эсэх (2) .....                                      | 34 |
| График 19. | Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангасан эсэх (3) .....                                      | 35 |
| График 20. | Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангасан эсэх (4).....                                       | 35 |
| График 21. | Сургуулийн ажилчдаас тусламж авч чаддаг эсэх.....   | 36 |
| График 22. | Суралцагчид сургуулийн орчинд зодож, зодуулж байсан эсэх ..   | 36 |
| График 23. | Гэрт болон сургууль дээр тохиолдсон сайхан зүйлсийн ганцаарчлан ярилцдаг эсэх.....  | 37 |
| График 24. | Ямар давтамжтай ярилцдаг .....  | 37 |
| График 25. | Таагүй явдлын талаар ярилцдаг эсэх .....  | 37 |
| График 26. | Ямар давтамжтай ярилцдаг.....   | 37 |
| График 27. | Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж буй, өртөж болзошгүй нөхцөлтэй таарвал та ямар нэгэн айдасгүйгээр шууд мэдээлэх эсэх..... | 38 |
| График 27. | Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж буй, өртөж болзошгүй тохиолдлыг та ямар хэлбэрээр мэдээлэх вэ?.....                       | 38 |
| График 28. | Сургуульд санал хүсэлтийн хайрцаг байдаг эсэх .....   | 39 |
| График 29. | Хүүхдийнхээ сургуульд явах замыг аюулгүй гэдэгт итгэлтэй байдаг эсэх .....  | 39 |



|            |  |    |
|------------|--|----|
| График 30. | Хүүхэд тань сэтгэл амар тайван, таатай орчинд сурдаг эсэх ..   | 40 |
| График 31. | Сургууль эрүүл аюулгүй байхын тулд хийх зүйлс .....  | 42 |
| График 32. | Сургуулиас хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг эхчүүдэд зориулсан үйл ажиллагаануудад сэтгэл хангалуун байдаг эсэх ..             | 43 |
| График 33. | Хүүхэд хамгааллын бодлоготой болсноор сургуулийн орчин аюулгүй болсон эсэх .....   | 43 |
| График 34. | Хүүхэд хамгааллын бодлоготой болсноор сургуулийн орчин өөрчлөгдсөн эсэх.....   | 44 |
| График 35. | Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд хийгдсэн ажлын үр дүнд ямар нэгэн эерэг өөрчлөлт гарсан эсэх .....                          | 44 |
| График 36. | Дотуур байрны орчин нөхцөл .....   | 46 |
| График 37. | Өрөөндөө хичээлээ хийх хүрэлцээтэй ширээ, сандалтай эсэх ....  | 46 |
| График 38. | Өрөөний цонх нь хөшигтэй эсэх .....  | 47 |
| График 39. | Өрөөний хаалга түгжээтэй эсэх .....  | 47 |
| График 40. | Эргэн тойрон гэрэлтүүлэгтэй эсэх.....  | 48 |
| График 41. | Гаднаа камертай эсэх.....  | 48 |
| График 42. | Бие засах газрын байрлал.....  | 48 |
| График 43. | Бие засах газар гадаа байрладаг бол хүндрэл байдаг эсэх ....   | 49 |
| График 44. | Бие засах газар дотор байрладаг бол хүндрэл байдаг эсэх....  | 49 |
| График 45. | Дотуур байранд чөлөөт цагаа өнгөрүүлэх өрөө байдаг эсэх ..   | 50 |
| График 46. | Өрөөтэй бол хэрхэн ашигладаг вэ?.....  | 50 |
| График 47. | Дотуур байранд гадны хүн байралдаг эсэх.....   | 50 |
| График 48. | Дотуур байранд дурдсан зүйлс байдаг эсэх.....  | 51 |
| График 49. | Дотуур байрны багш нар ямар үйл ажиллагаа зохион байгуулдаг вэ?.....   | 51 |
| График 50. | Дотуур байрны багш нар хүүхэд хамгааллын ямар үйл ажиллагаа зохион байгуулдаг вэ?.....   | 52 |
| График 51. | Дотуур байранд хүүхэд хамгааллын үйл ажиллагаа төлөвлөхдөө чиний саналыг хэрхэн авдаг вэ? .....                                | 52 |
| График 51. | Өөрт тулгарсан асуудлаа дотуур байрны багштайгаа ярилцдаг эсэх .....   | 53 |
| График 52. | Тийм бол асуудлаа шийдэхэд тусалдаг эсэх .....   | 53 |
| График 53. | Асуудлыг шийдэхэд хэрхэн тусалсан бэ? .....  | 54 |
| График 54. | Дотуур байрны багш таагүй ханддаг эсэх.....  | 54 |
| График 55. | Таагүй ханддаг бол хэрхэн ханддаг вэ? .....  | 55 |
| График 56. | Дотуур байрны багш нь ямар байгаасай гэж хүсдэг вэ? .....  | 55 |
| График 57. | Дотуур байрандаа өөрийн хүссэн 3 өөрчлөлтөө хийх боломж олдвол юуг хамгийн түрүүнд өөрчлөх вэ? .....                           | 56 |
| График 58. | Таны хүүхэд дотуур байранд элдэв дарамгүйгээр амар тайван байх боломжтой эсэх .....  | 56 |
| График 59. | Хүүхэд хамгааллын бодлоготой болсноос хойш дотуур байрны орчин сайжирсан эсэх.....   | 57 |
| График 60. | Хүүхэд хамгааллын бодлогтой болсноос хойш хүүхэд тань дотуур байрандаа гарсан өөрчлөлтийн талаар ярьж байхыг сонссон эсэх..... | 57 |

## ОРШИЛ/СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, суралцагчийг аливаа хүчирхийлэл, дарамт дээрэлхэлт, бие махбодын шийтгэл, гэмт хэрэг, хорт зуршлаас сэргийлэх, нөхцөлийг бүрдүүлэх шаардлагыг үндэслэн Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/476 тоот тушаалаар ЕБС-ийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлогыг (ХХБ) батлан гаргасан.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенци, Монгол Улсын Боловсролын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудад үндэслэн ЕБС-ийн орчин дахь ХХБ-оор хүүхэд гэр бүл, сургууль, нийгмийн бүхий л орчинд аливаа хүчирхийллээс хамгаалуулах эрхтэй бөгөөд насанд хүртлээ эцэг эх, гэр бүл болон төрийн онцгой халамж, хамгаалалтад байхаар заасан. ЕБС-ийн ХХБ нь үндэслэл, зорилго, зорилт, баримтлах зарчим, хамрах хүрээ, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, зохион байгуулалт, хяналт үнэлгээ, хүрэх үр дүн гэсэн 9 бүлэг бүхий баримт бичиг юм.

ХХБ нь сургууль, хүүхэд хамгааллын холбогдох байгууллага, иргэний нийгэм, салбар мэргэжлийн холбоодын хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар ЕБС-ийн суралцагчийг аливаа хүчирхийлэл, дарамт дээрэлхэлт, үл хайхрах байдал, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлэх, сургуулийн орчин дахь суралцагчийн хамгааллын үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготой.

ОИН.МН  
СУДАЛГААНЫ САН

---

## ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хөндлөнгийн үнэлгээний зорилго нь БСШУС-ын сайдын 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/476 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого”-ын хэрэгжилт, үр дүн, үр нөлөөнд хөндлөнгийн үнэлгээ хийж, хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг судлан дүгнэлт, зөвлөмж, санал боловсруулахад оршино.


Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж ажилласан. Үүнд:

- Сургуулийн түвшинд ХХБ боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх үйл явцад олон талын оролцоог хангасан эсэхийг тодорхойлох
- Сургуулийн ХХБ нь сургуулийн хэмжээнд баримталж буй бусад баримт бичигтэй уялдсан эсэхийг тодорхойлох
- Сургуулийн ХХБ-ын боловсруулалт, хэрэгжилт, хяналт үнэлгээний үйл явц (бодлогын процесс) дахь тулгамдаж буй асуудлыг тодорхойлж улмаар шийдвэрлэх арга замыг санал болгох
- Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын талаарх эцэг эхийн сэтгэл ханамжийг тодорхойлох
- Сургуулийн орчинд хүүхэд хамгааллын чиглэлээр гарсан өөрчлөлтийг тодорхойлох (бодлогын үр дүн, үр нөлөө)

## ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ҮР ДҮН

Хөндлөнгийн үнэлгээний хүлээгдэж буй үр дүнг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Сургуулийн ХХБ-ын боловсруулалт, хэрэгжилт, үр дүнгийн талаар нарийвчилсан өгөгдөл, мэдээлэл
- Үнэлгээний тайлан
- Үнэлгээний санал, зөвлөмж
- Нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөө



## ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛТ

Үнэлгээний багийн зүгээс дараах асуултыг дэвшүүлж хөндлөнгийн үнэлгээг хийлээ. Үүнд:

- Сургуулийн ХХБ боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх үйл явцад олон талын оролцоо бүрэн хангагдсан уу?
- Сургуулийн ХХБ нь сургуулийн хэмжээнд баримталж буй бусад баримт бичигтэй уялдсан уу?
- Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл явцад оролцогч болон үр шим хүртэгч талууд сэтгэл ханамжтай байна уу?
- Сургууль ХХБ-той болсноор сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр өөрчлөлт гарсан уу?

## АРГА ЗҮЙ

### Хамрах хүрээ

Үнэлгээний хамрах хүрээ нь ЕБС-ийн ХХБ-ын хэрэгжилт бөгөөд энэхүү бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх үйл явцад хамааралтай талуудын оролцоо, сургуулийн бусад баримт бичигтэй уялдсан байдал, хэрэгжилтийн үр дүн, талуудын сэтгэл ханамжид дүн шинжилгээ байна.

### Эх олонлог, түүвэр

Хөндлөнгийн үнэлгээний эх олонлогийг нийт төрийн өмчийн сургуулийн тоо, нийт суралцагчийн тоо гэсэн үзүүлэлтээр дараах хүснэгтээр гаргав. Үүнд:

#### Хүснэгт 1. Хөндлөнгийн үнэлгээний эх олонлог

| Үзүүлэлт                                 | Хичээлийн жил |           |           |
|--|---------------|-----------|-----------|
|  | 2018-2019     | 2019-2020 | 2020-2021 |
| Төрийн өмчийн сургуульд суралцагчийн тоо | 640,449       | 680,837   | 712,353   |
| Үүнээс: Дунд ангид                       | 200,806       | 222,153   | 238,348   |
| Төрийн өмчийн нийт сургуулийн тоо        | 820           | 839       | 848       |

Эх сурвалж: 1212.mn

Хөндлөнгийн үнэлгээний сургуулийн түүвэрт “БНБТ!” ИНҮЭ-ийн салбар зөвлөл, Сургуулийн эцэг эх, багшийн холбоо (СЭЭБХ) ажиллаж буй сургуулийг үнэлгээ хийх хугацаа, нөөц боломжийг тооцон нийт 50 сургуулийг сонгосон боловч цар тахлын нөхцөл байдал, бусад хүчин зүйлээс шалтгаалан 34 сургуулиас дараах байдлаар түүврийг бүрдүүлсэн болно. Үүнд:

**Хүснэгт 2.** Хөндлөнгийн үнэлгээний сургуулийн түүвэр

| Д.д | Газар      | Сургуулиуд                         |
|-----|------------|------------------------------------|
| 1   | Багануур   | Оюуны эрин                         |
| 2   |            | Боловсрол ЦС                       |
| 3   |            | Гүн галуутай ЦС                    |
| 4   | Налайх     | Насан туршийн боловсролын сургууль |
| 5   |            | 109-р сургууль                     |
| 6   |            | Голомт ЦС                          |
| 7   |            | Эрдмийн Оргил ЦС                   |
| 8   |            | 119-р сургууль                     |
| 9   | Баян-Өлгий | Улаанхус сумын 3-р сургууль        |
| 10  |            | Цэнгэл сумын 1-р сургууль          |
| 11  |            | Өлгий сумын 4-р сургууль           |
| 12  |            | Өлгий сумын 6-р сургууль           |
| 13  |            | Бугат сумын ЕБС                    |
| 14  | Дархан     | 14-р сургууль                      |
| 15  |            | 16-р сургууль                      |
| 16  | Өмнөговь   | Даланзадгадын 1-р сургууль         |
| 17  |            | Даланзадгадын 4-р сургууль         |
| 18  |            | Даланзадгадын 5-р сургууль         |
| 19  |            | Даланзадгадын 7-р сургууль         |
| 20  |            | Ханхонгор сумын сургууль           |
| 21  | Завхан     | Дэвшил сургууль                    |
| 22  |            | Жавхлан ЦС                         |
| 23  |            | Тосонцэнгэл сумын 2-р сургууль     |
| 24  |            | Тэлмэн сумын сургууль              |
| 25  |            | Улиастай 3-р сургууль              |
| 26  |            | Улиастай 4-р сургууль              |
| 27  |            | Чандмань Эрдэнэ сургууль           |
| 28  | Архангай   | Өлзийт сумын сургууль              |
| 29  |            | Эрдэнэбулган сумын 4-р сургууль    |
| 30  | Өвөрхангай | Хужирт сумын сургууль              |
| 31  |            | Арвайхээр сумын 2-р сургууль       |
| 32  | Хөвсгөл    | Авъяас                             |
| 33  |            | Улаан-Уул сумын сургууль           |
| 34  | Булган     | Эрдмийн өргөө ЦС                   |

Ганцаарчилсан ярилцлагыг хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүд буюу захирал, нийгмийн ажилтан, багш, эцэг эхийн зөвлөл болон дотуур байрны багш гэсэн зорилтот бүлгээс авсан.

Асуулгыг дунд анги удирдсан багш, дунд ангийн суралцагч, тэдний эцэг эх гэсэн зорилтот бүлгээс авч мэдээлэл цуглуулсан.

Асуулгын болон ярилцлагын судалгааны түүврийн төлөөллийг дараах байдлаар бүрдүүлэв. Үүнд:

**Хүснэгт 3.** Сургуулиас авсан асуулгын болон ярилцлагын судалгааны түүвэр

| Судалгааны арга         | Оролцогчид                  | Түүвэр |
|-------------------------|-----------------------------|--------|
| Ганцаарчилсан ярилцлага | Эцэг эхийн зөвлөлийн дарга  | 22     |
|                         | Сургуулийн захирал          | 28     |
|                         | Сургуулийн нийгмийн ажилтан | 32     |
|                         | Дотуур байрын багш          | 10     |
|                         | Бусад                       | 11     |
| Асуулга                 | Багш                        | 572    |
|                         | Эцэг эх                     | 1864   |
|                         | Суралцагч                   | 2695   |

## СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Хөндлөнгийн үнэлгээний хүрээнд баримт бичгийн судалгаа, асуулга, ганцаарчилсан ярилцлагын аргыг ашиглан өгөгдөл мэдээллийг цуглуулсан. Үнэлгээний хүрээнд төрийн зарцуулалтыг мөшгих судалгаа авахаар төлөвлөсөн боловч судалгааны өгөгдлийг цуглуулахад бэрхшээл учирснаас шалтгаалан энэхүү судалгааг хийгээгүй болно.

Сургуулийн ХХБ-ын үйл явцад оролцогч, сонирхогч, үр шим хүртэгч талууд болон судалгааны үндсэн аргын хүрээн дэх хэрэглэгдэхүүн, мэдээлэл цуглуулах төлөвлөгөөг гарган ажилласан. Үүнд:

**Хүснэгт 4.** Сургуулийн ХХБ-ын үйл явцад оролцогч, сонирхогч, үр шим хүртэгч тал ба судалгааны арга, хэрэглэгдэхүүн, өгөгдөл цуглуулах төлөвлөгөө

| № | Оролцогч талууд                  | Судалгаа                |           |         |
|---|----------------------------------|-------------------------|-----------|---------|
|   |                                  | Баримт бичгийн судалгаа | Ярилцлага | Асуулга |
| 1 | Хүүхэд хамгааллын хамтарсан баг  | +                       |           |         |
| 2 | Сургуулийн захирал               | +                       | +         |         |
| 3 | Сургуулийн нийгмийн ажилтан      | +                       | +         |         |
| 4 | Дунд анги удирдсан багш          |                         |           | +       |
| 5 | Дунд ангийн суралцагч            |                         |           | +       |
| 6 | Дунд ангийн суралцагчийн эцэг эх |                         | +         | +       |
| 7 | Дотуур байрын багш               |                         | +         |         |

---

**Баримт бичгийн судалгаагаар** дараах төрлийн мэдээллийг цуглуулсан. Үүнд:

1. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам
2. Хөдөлмөрийн гэрээ
3. Сургууль хөгжүүлэх хөтөлбөр
4. Сургуулийн стратеги төлөвлөгөө
5. Сургалтын бодлого
6. Багшийн хөгжлийн хөтөлбөр
7. Багш сонгон шалгаруулах журам
8. Багшийн ёс зүйн дүрэм
9. Архив, албан хэргийн хөтлөлт, хадгалалт, хамгаалалтын журам
10. Орчны стандартыг боловсруулах
11. ЕБС-ийн дүрэм
12. Ажлын байрны тодорхойлолт
13. Сургууль, эцэг эхийн Гурвалсан гэрээ
14. ХХ-ын ёс зүйн дүрэм
15. Мэдээлэх журам

**Асуулгын аргаар** эцэг эх, багш, суралцагчдын хүүхдийн эрх, хамгааллын талаарх ойлголтын түвшинг тогтоох, сургуулийн ХХБ боловсруулах, хэрэгжүүлэх, хянах явц дахь олон талын оролцоо, сэтгэл ханамжийн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулсан. Асуулгыг цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Google form ашиглан цахим хэлбэрээр авсан. Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл аймгийн 22 сум, Улаанбаатар хотын Багануур, Налайх дүүргийн нийт 34 сургуулийн 572 багш, 2695 суралцагч, 1862 эцэг эхээс сургуулийн ХХБ-ын хэрэгжилт, үр дүнд сэтгэл ханамжийн судалгааг 2021 оны 10 дугаар сарын 1-нээс 11 дүгээр сарын 25-ны хооронд цахим хэлбэрээр явуулсан.

**Ганцаарчилсан ярилцлагын аргаар** сургуулийн ХХБ боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх явц дахь олон талын оролцооны талаарх мэдээлэл цуглуулсан.

Ганцаарчилсан ярилцлагад дээрх сургуулийн захирал, нийгмийн ажилтан, эцэг эх, дотуур байрны багш нийт 103 төлөөлөл оролцсон. Үүнээс:

- Сургуулийн захирал 28
- Нийгмийн ажилтан 32
- Эцэг эхийн зөвлөлийн дарга 22
- Дотуур байрны багш 10 (дотуур байртай сургууль 18)
- Бусад (багш, сургалтын менежер, сургуулийн эмч) 11.

## МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Цуглуулсан өгөгдөл, мэдээллийг нийгмийн судалгааны мэдээллийг боловсруулдаг SPSS программд хөрвүүлэн боловсрууллаа. Боловсруулсан өгөгдөл мэдээлэлд

1) Контент шинжилгээ

2) Харьцуулсан шинжилгээ

3) Шалтгаан, үр дагаврын шинжилгээ хийж үнэлгээний үр дүнг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг ашиглан дүгнэхийг зорьсон.

Контент шинжилгээг түүвэрт сонгогдсон сургуулиудын ХХБ, сургууль дээр баримталж буй бусад баримт бичигт дүн шинжилгээ хийж, хүүхэд хамгааллын бодлогыг тавигдсан шаардлагын дагуу боловсруулсан эсэх, хүүхэд хамгааллын бодлогыг бусад баримт бичигтэй уялдуулсан эсэхийг тодруулах зорилгоор хийсэн.

Харьцуулсан шинжилгээг сургуулийн хүүхэд хамгааллын бодлогыг сургууль дээр баримталж байгаа бусад баримт бичигтэй уялдуулсан эсэх талаар хийсэн.

Сургуулийн ХХБ боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх үйл явцыг хэрэгжүүлж, талуудын ойлголтыг нэмэгдүүлж, энэ үйл явцад олон талын оролцоог хангаснаар хүүхэд хамгааллын тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэгдэнэ гэсэн харилцан хамаарлыг үүсгэхийг зорьсон. Иймд хөндлөнгийн үнэлгээгээр энэхүү харилцан хамаарал үүсч буй эсэхэд шалтгаан, үр дагаврын шинжилгээ хийсэн.

## ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЛ БА БЭРХШЭЭЛ

Энэхүү хөндлөнгийн үнэлгээг хийхэд дараах хязгаарлагдмал тал ба бэрхшээл тулгарсан. Үүнд:

- Үнэлгээнд хамрагдсан сургуулиудын нөхцөл байдал нь сонгогдсон сургуулиудын нөхцөл байдлыг илэрхийлэх бөгөөд нийт төрийн өмчийн ЕБС-ийн нөхцөл байдлыг илэрхийлэхгүй болно.
- Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт, үнэлгээний талаарх мэдээлэл нь бүрэн бус, олон талын оролцоог хангасан талаарх баримтжуулалт хийгдээгүй.
- Мэдээлэл цуглуулах үйл явц нь Ковид-19 цар тахлын хөл хорио, хязгаарлалтаас шалтгаалан оролцогч талуудтай ярилцлага хийх боломжийг хязгаарласны зэрэгцээ мэдээлэл цуглуулах үйл явцыг удаашруулсан.



## Үнэлгээний үр дүн

# БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЖ ҮНЭЛЭХ ҮЙЛ ЯВЦАД ОЛОН ТАЛЫН ОРОЛЦООГ ХАНГАСАН ЭСЭХ

### а. БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ

Ганцаарчилсан ярилцлагад оролцогчид **“ХХБ” боловсруулахад хэн хэнтэй хамтарч, хэрхэн боловсруулсан бэ?** гэсэн асуултад хариулахдаа хүүхэд хамгааллын оролцогч талуудад захирал, нийгмийн ажилтан, сургалтын менежер, хүүхэд хамгааллын баг, ажлын хэсэг, анги удирдсан багш, эцэг эх, багш, суралцагч, эмч, дотуур байрны багш, захирлын дэргэдэх зөвлөл, заах аргын нэгдлийн ахлагч, ажилчдын төлөөлөл, багийн засаг дарга зэрэг маш олон талыг хамруулж ойлгодог нь харагдаж байсан. Үүнээс:

- Захирлуудын 50%
- Нийгмийн ажилтнуудын 28%
- Эцэг эхийн төлөөллийн 23% нь 2-оос дээш оролцогч талыг ХХБ боловсруулахад оролцуулсан гэж хариулсан байна.

Дээрх хариултаас харахад, сургуулийн захирал, нийгмийн ажилтан, эцэг эхийн хооронд ойлголтын зөрүү байгаа нь харагдаж байна. Үүн дотроо нийгмийн ажилтнуудын 19% нь сургуулийн ХХБ-ыг ганцаараа боловсруулсан гэж хариулсан байхад энэ талаар захирлууд дурдаагүй байгаа нь захирал, нийгмийн ажилтны ажлын уялдаа холбоо муу, энэ асуудлыг нийгмийн ажилтан л хариуцдаг гэсэн ойлголттой байгааг харуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь ХХБ-т **“Сургуулийн захирал нь хүүхэд хамгааллын асуудлыг хариуцах бөгөөд сургуулийн нийгмийн ажилтан, анги удирдсан багш, эмч, сэтгэл зүйч нарын төлөөллөөс бүрдсэн хүүхэд хамгааллын багтай хамтран зохион байгуулна. Энэхүү баг нь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж, зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина”** гэж заасан байхад ихэнх захирал өөрсдөө энэ ажлыг хариуцах албан тушаалтан гэдгээ ойлгоогүй, хүүхэд хамгааллын багт хэн хэн байх, ямар ажлууд хэрэгжүүлэх нь тодорхойгүй, зөвхөн нийгмийн ажилтанд хамаатай, тэдний ажил үүрэг гэсэн ойлголттой байгаа нь ажиглагдсан.

**Хэрхэн боловсруулсан бэ?** гэсэн оролцооны арга, хэлбэрүүдийг тодруулах асуултад оролцогчдын дийлэнх буюу 85 орчим хувь нь огт хариулаагүй байгаа нь анхаарал татаж байна. Цөөн оролцогч санал асуусан, ярилцсан гэж хариулсныг задалбал:


- Захирал: Санал асуусан 15%, хүүхэд, эцэг эхчүүдээс авсан судалгаанд үндэслэсэн 3,8%, тулгамдаж буй асуудлыг дэвшүүлэн ярилцсан гэж 7,7% хариулсан,
- Нийгмийн ажилтан: Санал асуусан 9%, ажлын хэсгээр ярилцсан гэж 3%,
- Эцэг эхийн төлөөллийн 4,5% нь ярилцаж санал асуусан гэж хариулсан байна.

Сургуулийн ХХБ боловсруулахдаа олон талыг оролцуулсан гэж хариулж байгаа нь сайшаалтай боловч оролцуулж байгаа арга хэлбэрийн хувьд санал авсан гэж захирал, нийгмийн ажилтнуудын дөнгөж 9-15% нь хариулсан. Үүнээс үзэхэд, оролцооны арга хэлбэрүүдийг ашиглаагүй, ихэнхдээ удирдлагын баг дотроо ярилцаад хийсэн гэсэн хариулт байгаа нь учир дуталдалтай байна.

Мөн захирал, нийгмийн ажилтнуудын хувьд эцэг эхийн төлөөллийг оролцуулсан гэж 86% хариулсан боловч эцэг эхийн зөвлөлийн дарга нар өөрсдөө оролцсон гэсэн хариулт өгөөгүй.


Багш, эцэг эхчүүдээс авсан асуулгад ХХБ боловсруулах үйл явцын талаар дараах хариултыг өгсөн байна.

**График 1.** Танай хүүхдийн сургуульд ХХБ байдаг уу?




Сургуульд ХХБ байдаг эсэхийг асуухад багш нарын 80.1% нь харин эцэг эхчүүдийн 37.2% нь байдаг гэж хариулсан. Эцэг эхчүүдийн 62.8% нь мэдэхгүй, байхгүй гэсэн хариулт өгсөн байгаагаас үзэхэд сургуульд ХХБ байдаггүй, хэрэв байдаг бол эцэг эхчүүдийн мэдээлэл маш дутмаг байна.

**График 2.** ХХБ боловсруулахад таны саналыг авсан уу?



Асуулгаар багш, эцэг эхчүүдээс ХХБ боловсруулахад саналыг нь авсан эсэхийг асуухад багш нарын 58.9%, эцэг эхчүүдийн 70.8% нь санал өгөөгүй гэж хариулсан нь ХХБ боловсруулах явцад багш, эцэг эхчүүдийн оролцоог хангахгүй байгааг нотолж байна. Энэ нь эцэг эхчүүдийн ганцаарчилсан ярилцлагад өгсөн хариулттай нийцэж байгаа юм.

**График 3.** Хэрэв тийм бол ямар хэлбэрээр санал авсан бэ?



ХХБ-д санал өгсөн гэж хариулсан (багш нарын 41.1%, эцэг эхчүүдийн 29.2%) оролцогчдоос ямар хэлбэрээр санал авсныг тодруулахад, дийлэнх нь хурлаар болон цахимаар (фэйсбүүк групп, чат) санал өгсөн гэж хариулсан. Нийтийн

хэлэлцүүлэг, олон талт хэлэлцүүлэг, бичгэн санал асуулгын хэлбэрээр санал авахад багш нарыг эцэг эхчүүдээс илүү оролцуулж байгаа нь ажиглагдаж байна. Эцэг эхчүүдээс авсан ганцаарчилсан ярилцлагын үеэр санал авсан хэлбэрийг тодруулахад 85% нь ямар нэгэн хариулт өгөөгүй нь эцэг эхийг оролцуулах үйл ажиллагаа дутмаг байгааг харуулж байна.

## 6. ҮЙЛ АЖИЛЛАГАА ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

ХХБ-ын 7 дугаар бүлэгт “Хүүхэд хамгааллын баг ХХБ-ыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж...” гэж заасны дагуу сургууль дээр ХХБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах үйл явц, оролцооны талаар тодрууллаа.

**“ХХБ хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад хэн хэнтэй хамтарч боловсруулсан бэ?** гэсэн асуултын хариултаас үзэхэд, 2-оос дээш оролцогч тал хамтран (эцэг эхийг оролцуулан) боловсруулсан гэж захирлуудын 65%, нийгмийн ажилтнуудын 21% хариулсан бол эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл өөрсдөө оролцсон гэсэн хариулт өгөөгүй.

**Хэрхэн боловсруулсан бэ?** гэсэн асуултад дүгнэлт өгөхөөр тодорхой хариулт байхгүй, нийтлэг хариулаагүй орхигдуулсан байна.


**Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд суралцагч, эцэг эх, багш, дотуур байрны багш, ажилтнууд болон бусад талыг хэрхэн оролцуулдаг вэ?** (Танай сургуулийн ХХБ-ыг хэрэгжүүлэхэд олон талын оролцоог хангаж ажилладаг туршлага юу вэ?) гэсэн асуултад олон талыг оролцуулдаг гэж

- Захирлуудын 67,8%
- Нийгмийн ажилтны 50%
- Эцэг эхийн төлөөллийн 18% хариулсан.

Эцэг эхчүүд зөвхөн эцэг эх, багш, суралцагчийн гурвалсан гэрээ байгуулсан гэж хариулсан бөгөөд гурвалсан гэрээнд хүүхэд хамгааллын талаар ямар асуудал тусгасан нь тодорхойгүй байна.


**“ХХБ нь өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш, дотуур байрны багш, ажилтан, гэрээт ажилчин, сайн дурын ажилтан, суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад хамаарна”** гэж заасны дагуу захирал, нийгмийн ажилтны талаас илүү хувь нь бүх талыг оролцуулсан гэж хариулсан нь олон талын төлөөллийг оролцуулах талаар ойлголттой байгаа хэдий ч харамсалтай нь эцэг эхийн төлөөллийн 18% нь л зөвхөн гурвалсан гэрээ байгуулах замаар оролцож байгаа талаараа дурдсан нь эцэг эхийн оролцоо хязгаарлагдмал байгааг илэрхийлж байна.

**График 4.** ХХБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөөний талаарх багш нарын хариулт



Асуулгад хариулсан багш нарын 77.6% нь ХХБ хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө байгаа, бодлого төлөвлөгөө боловсруулахад багш нарын 43.6% нь санал авсан гэж хариулсан боловч үнэлгээнд хамрагдсан сургуулиудын нэг нь ч хөтөлбөр, төлөвлөгөө ирүүлээгүй.

**График 5.** Сургуулийн орчинд суралцагчдад учирч болох эрсдэлийг үнэлэхэд оролцсон эсэх



Сургуулийн орчны эрсдэлийг үнэлэх ажилд багш нарын 47.4%, эцэг эхчүүдийн 22.7% нь оролцож байсан гэж хариулсан. Харин мэдэхгүй, оролцож байгаагүй гэж багш нарын 12.1% нь, эцэг эхчүүдийн 44.9% хариулж байгаагаас үзэхэд багш, эцэг эхчүүдийн оролцооны зөрүү их байна. Эцэг эхчүүдийн оролцоо хязгаарлагдмал байгаа талаарх өмнөх үр дүнг бататгаж байна.

**Хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахад хэрхэн оролцуулдаг вэ?** гэсэн асуултад нийт ярилцлагад оролцогчдын дийлэнх буюу 71,5% нь хариулаагүй, 28,5% нь тодорхой хэмжээгээр хариулснаас 14% нь асуулттай холбоогүй хариултууд байгаа нь хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахад олон талын оролцоог хангаж чадахгүй байгааг нотолж байна.

## **в. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ**

ХХБ-ын 3-р бүлэгт дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр заажээ.

1. Сургууль, дотуур байранд хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй материаллаг болон нийгэм, сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг ханган ажиллана.
2. Мэдээллийг хүлээн авах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг эрсдлээс хамгаалах, түүнийг бууруулахад үнэлгээ хийж, арга хэмжээ авна.
3. Хохирогч хүүхдэд боловсролын үйлчилгээг тасралтгүй олгон, хүүхэд хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

Энэхүү 3 зорилтыг хэрэгжүүлэх үйл явц, түүнд олон талын оролцоог хэрхэн хангаж байгааг тодрууллаа.

**“Анги удирдсан багш, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр суралцагч болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдын дунд хүүхдийг аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдийг хүчирхийллийн бус, уламжлалт аргаар хүмүүжүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, үүнд шаардлагатай зардлыг сургуулийн хүүхэд хамгаалалд зориулсан төсвөөс гаргадаг байх”** гэж заасан байгаа ч хөтөлбөр, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг тусгадаг талаар нэг сургуулиас бусад сургуулийн захирал дурдаагүй байна.

Харин дээрх асуултад тодорхой хариулт өгсөн дараах сургуулиудыг онцлууштай. Үүнд:

- Дархан хотын 16-р сургуулийн захирал: Анги удирдсан багш, нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын ажилд чухал үүрэгтэй ажилладаг. Эцэг эх болон суралцагчдад хүүхэд хамгааллын сургалт, нөлөөллийн үйл ажиллагаагаар дамжуулан мэдлэг мэдээлэл түгээх зорилгоор үйл ажиллагаандаа татан оролцуулдаг. Хүүхэд хамгааллын зарим үйлчилгээнд хяналт тавихад эцэг эхчүүдийг татан оролцуулдаг. Тухайлбал, жил бүр орчны эрсдэлийн үнэлгээ хийхэд суралцагчдын зөвлөлийн гишүүн суралцагч болон эцэг эхийн төлөөллийг заавал оролцуулдаг. Мөн үдийн цай хөтөлбөрийн амт, чанарт үнэлгээ хийхэд эцэг эхчүүдийг оролцуулдаг.

- Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын сургуулийн захирал:
- Суралцагчдаас эрсдэлийн үнэлгээ авч, зөвлөгөө сургалт өгдөг. Эцэг эхчүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авах, эрсдэл дээр тулгуурлан төлөвлөгөөг боловсруулдаг. Анги удирдсан багш нартай хамтран хүүхэд хамгааллын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Дотуур байрны багш сургалт, зөвлөгөө өгч, хүүхэд хамгааллын багтай хамтран төлөвлөгөө боловсруулан ажилладаг. Сургуулийн ажилтнууд эрсдэлээс хамгаалах талаар хурал зөвлөгөөн дээр хүүхэд хамгааллын төлөвлөгөөг боловсруулан хамтран ажиллах, хүүхэд бүрт ээлтэй орчинг бүрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.
- Налайх дүүргийн Эрдмийн Оргил цогцолбор сургуулийн захирал: Сургуулийн ажилтнууд хүүхэд хамгааллын чиглэлээр ойлголттой болсноор суралцагчдыг суралцах эрүүл, аюулгүй, цэвэр орчинг бүрдүүлэхийн зэрэгцээ үе тэнгийн хүчирхийлэл, бусад сургуулийн суралцагчдын хоорондын маргааны талаар мэдсэн тохиолдолд мэдээлэх, таслан зогсоох арга хэмжээ авдаг болсон.
- Багануур дүүргийн Боловсрол цогцолбор сургуулийн захирал: Хүүхэд хамгааллын баг нийгмийн ажилтнаас хамааралтай, заагдсан ажлууд юу юу хийгдэх вэ гэдгийг санхүүтэй яриад төсвийн хүрээнд шийдээд явдаг. Жишээ нь, хүүхэд хамгааллын хүрээнд бага, дунд сургуулиудад камержуулалт, нойлын халаалтаа сайжруулсан. Ер нь судалгаагаа хийж төсвөө шийдэж байна. Гар утас, юмаа алдсан хэргүүд гардаг, камер шүүгээд сайн харагдахгүй, тийм учраас камерын чанарыг сайжруулахын тулд дүүрэгт хүсэлт гаргаад иргэдийн хурлаар 10 камер шийдэж өгсөн гэсэн хариултуудыг өгчээ.


**ХХБ хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг хэн хэнд хэрхэн яаж сурталчилж таниулсан бэ?** гэсэн асуултад дараах байдлаар хариулжээ.

Багш, суралцагч, эцэг эхчүүдэд сурталчилж таниулсан гэдэг хариулт нийтлэг байгаа ч талуудын хариулт хоорондоо зөрүүтэй байна.

Жишээлбэл:

- Захирлуудын 42.8% нь суралцагч, эцэг эхчүүдэд сургалтаар танилцуулсан гэсэн боловч эцэг эхчүүдийн 27% эцэг эхийн хурлаар танилцуулсан гэжээ.
- Захирлуудын 14.2% нь багш, ажилчдад хурлаар танилцуулсан гэсэн бол багш нарын 50% нь багш, ажилтанд хурлаар танилцуулсан гэж хариулжээ.

**График 6.** Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрхэн танилцуулсан бэ?




ХХБ-ыг багш нарын 49.6%, эцэг эхийн 39.3% нь хурал дээр танилцуулсан гэж хариулсан бол эцэг эхчүүдийн 42.6% нь бусад хэлбэрээр танилцуулсан буюу мэдэхгүй, танилцуулаагүй, фэйсбүүкээр танилцуулсан, групп дээр мэдээлсэн, онлайн уулзалт зэрэг хариултыг өгсөн байна.

ХХБ-ын 3 зорилтын хүрээнд 30 орчим тодорхой үйл ажиллагааг заасан байгаа боловч ярилцлагад оролцогчдын хариулт сургалт, хурал, үнэлгээ, тараах материал, санал авах гэсэн цөөн үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байна.

ХХБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг оролцогч талуудад хэрхэн яаж таниулсан байдлыг асуулгын аргаар тодруулж үзлээ.

**График 7.** ХХБ-ыг албан ёсоор танилцуулсан эсэх




Сургуульд ХХБ байдаг гэж хариулсан нийт багш нарын 80.1%, нийт эцэг эхчүүдийн 37.2% нь ХХБ-г албан ёсоор танилцуулсан эсэхэд дараах байдлаар хариулсан байна.




Албан ёсоор танилцуулаагүй, мэдэхгүй гэж багш нарын 30.8%, эцэг эхчүүдийн 53.5% хариулсан байна. Эсрэгээрээ ХХБ-той албан ёсоор танилцсан гэж хариулсан багш нарын 69.2% буюу судалгаанд оролцсон нийт багш нарын 55.2%, эцэг эхчүүдийн 46.5% буюу судалгаанд оролцсон нийт эцэг эхчүүдийн 17.3% л хариулсан байгаагаас үзэхэд ХХБ-г сурталчлан таниулах үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.

**График 8.** Танилцуулсан бодлогыг ойлгосон эсэх



ХХБ-той албан ёсоор танилцсан нийт багш нарын 69%-иас ойлгосон эсэхийг асуухад 90 гаруй хувь ойлгосон гэж хариулсан бөгөөд энэ нь судалгаанд оролцсон нийт багш нарын 49.7%. ХХБ-той албан ёсоор танилцсан нийт эцэг эхчүүдийн 70 орчим хувь нь ойлгосон гэж хариулсан байгаа нь судалгаанд оролцсон нийт эцэг эхчүүдийн 12% болж байна. ХХБ-той танилцсан эцэг эхчүүдийн гуравны нэг нь ХХБ-ыг ойлгоогүй байгаа нь анхаарал татаж байна.

**График 9.** Сургуулийн орчинд суралцагчдад учирч болох эрсдэлийг багасгах ажилд оролцож байсан эсэх



Эрсдэлийг багасгах ажилд оролцож байгаагүй гэж багш нарын 45%, эцэг эхчүүдийн 69.7% хариулсан байгаа нь олон талын оролцоо хангалтгүй, ялангуяа эцэг эхчүүдийн оролцоог хангаж чадахгүй байгааг онцолмоор байна.

### г. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЕ ШАТ


ЕБС-ийн ХХБ-д **“Аймаг, нийслэлийн боловсролын газар, сум дүүргийн боловсролын хэлтэс нь харьяа нутаг дэвсгэрийн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байр бүрийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг эцэг эхийн зөвлөлтэй хамтран жил бүр хийж, үр дүн бүхий тайланг жил бүрийн 06 дугаар сарын 10-ны дотор Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүргүүлнэ”** гэж заасан байна.

Ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын дийлэнх нь **Сургууль, дотуур байрны хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хэн хэнтэй хамтарч хийдэг вэ?** гэсэн асуултад зөвхөн сургуулийн хүрээнд эцэг эхийн төлөөллийг оролцуулж ХХБ хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг гэж хариулсан. Энэ нь ХХБ-ын **“Аймаг, нийслэлийн боловсролын газар, сум дүүргийн боловсролын хэлтэс хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг эцэг эхийн зөвлөлтэй хамтран жил бүр хийнэ”** гэсэн заалт хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Зөвхөн Өвөрхангай аймгийн 2-р сургуулийн нийгмийн ажилтан Боловсролын газартай хамтран ХХБ-ын үнэлгээ, шинжилгээ хийж, сайжруулах арга хэмжээ авч ажилладаг гэж хариулсан нь сайшаалтай боловч эцэг эхийн зөвлөлтэй хамтардаг тухай дурдаагүй байна. Эндээс харахад, аймаг, нийслэлийн боловсролын газар болон дүүргийн боловсролын хэлтэс ч сургуулийн ХХБ-ын хэрэгжилтэд анхаарч ажилладаггүй, орхигдуулсан, үр дүн бүхий тайланг хугацаанд нь дээд байгууллагадаа хүргүүлж, харилцан уялдаа холбоотой ажиллаж чаддаг эсэх нь эргэлзээтэй байна.

Иймд сургуулийн ХХБ нь шат шатандаа хэрэгжихгүй байна гэж үзэж байна.

**График 10.** ХХБ-ын хэрэгжилтийн тайланг танилцуулдаг эсэх



---

Багш нарын 55.8% нь ХХБ-ын хэрэгжилтийн тайланг танилцуулсан гэж хариулсан бол 44.2% нь хэрэгжилтийн тайланг танилцуулаагүй, мэдэхгүй гэсэн хариулт өгч байгаа нь хэрэгжилтийн тайланг танилцуулах үйл явц хангалтгүй байгааг харуулж байна.

Ганцаарчилсан ярилцлагын **бодлогын хэрэгжилтээ сайжруулахад хяналт, үнэлгээний тайлангийн үр дүнг хэрхэн ашигладаг вэ?** гэсэн асуултад

- Захирал: ХХБ, үйл ажиллагаагаа шинэчлэн сайжруулахад ашигладаг 32%, хариулаагүй 10,7%. Мөн нийгмийн ажилтан мэднэ; ажлаа аваад удаагүй байгаа, эхлээд стратеги, төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж байна зэргээр хариулсан байна.
- Нийгмийн ажилтан: Тайлан гаргадаг; хичээлийн жилийн эцэст анги удирдсан багш нартай хамтран нэгдсэн тайлангаа аваад хичээлийн шинэ жил эхлэхэд хүүхэд хамгааллын төлөвлөгөө боловсруулахад ашигладаг зэргээр хариулсан. Гэхдээ цаасан дээр ХХБ-той ч нийгмийн ажилтан, анги удирдсан багш л хүүхдийн араас санаа зовж асуудал шийдэх нь их байна; хоорондын уялдаа холбоогүй, баримт бичгийг сайжруулан ажиллахад удирдлагын зүгээс дэмжлэг шаардлагатай; хичээлийн жилийн эхний хагаст сэтгэл ханамжийн судалгаа авч, эцэст харьцуулж, хүүхэд хамгааллын чиглэлээр нийт багш нараас тайлан авдаг; хагас жилээр үр дүнгээ тооцон ажилладаг; хэрэгжилтийн зурган тайлангаа 2 удаа Боловсролын газарт явуулдаг гэх мэт олон янзаар хариулсан нь хяналт, үнэлгээ ХББ-ын заалтын дагуу хэрэгжихгүй байгааг харуулж байна;
- Эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл: Хяналт, үнэлгээнд үндэслэн бодлогын хэрэгжилтээ сайжруулдаг 9%, мэдэхгүй ба хариулаагүй 27%, бусад нь ярилцаад л өнгөрдөг байх; зурагт тайлан мэдээг нийгмийн ажилтан цааш хүргүүлдэг; багш нарын зөвлөлд хүргүүлж, үнэлгээ шинжилгээ хийж, заавар авдаг; хичээлийн жилийн эцэст тайлант өдөрлөг зохион байгуулдаг; эцэг эхчүүд хүүхдэдээ анхаарал хандуулахдаа муу учир тэдний хандлагыг бага ч болов өөрчлөн хамтарч ажиллана гэх мэт тухайн асуултад холбогдолгүй хариултауд байсан.

ХХБ-д **“Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг жил тутам тогтмол үнэлж, үнэлгээний дүнд үндэслэн салбарын хүүхэд хамгааллын бодлогыг эргэн харах, сайжруулах арга хэмжээ авна”** гэж заасан байгаа ч Аймаг, нийслэлийн боловсролын газар ХХБ хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг заасан хугацаанд хийдэггүй гэсэн таамаглал ярилцлагад оролцогчдын хариултаас харагдаж байгаа учир оролцогчид бодлогын хэрэгжилтийг жил тутам тогтмол үнэлж, үнэлгээний дүнд үндэслэн салбарын хүүхэд хамгааллын бодлогыг эргэн харах, сайжруулах арга хэмжээ авдаг талаар хариулт өгөөгүй, өгөх ч боломжгүй юм.

## ХХБ СУРГУУЛИЙН БУСАД БАРИМТ БИЧГИЙН УЯЛДАА

ХХБ-ын баримт бичгийн дүн шинжилгээг үнэлгээнд хамрагдсан 34 сургуулийн 15 төрлийн 151 баримт бичигт үндэслэн хийсэн. Сургууль тус бүрээс ирсэн баримт бичгийн нарийвчилсан жагсаалтыг Хавсралтаас үзнэ үү.

1. Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журам
2. Хөдөлмөрийн гэрээ
3. Сургууль хөгжүүлэх хөтөлбөр
4. Сургуулийн стратеги төлөвлөгөө
5. Сургалтын бодлого
6. Багшийн хөгжлийн хөтөлбөр
7. Багш сонгон шалгаруулах журам
8. Багшийн ёс зүйн дүрэм
9. Архив, албан хэргийн хөтлөлт, хадгалалт, хамгаалалтын журам
10. Орчны стандартыг боловсруулах
11. ЕБС-ийн дүрэм
12. Ажлын байрны тодорхойлолт
13. Сургууль, эцэг эхийн гурвалсан гэрээ
14. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм
15. Мэдээлэх журам

Зарим сургууль БСШУС-ын сайдын 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн **А/476** тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого”, зарим сургууль Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын 1-р хавсралт дахь “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”-ийг хуулбарлан буулгаж баталгаажуулсан байна.

Үнэлгээнд хамрагдсан бүх сургууль ХХБ-оо баталгаажуулсан хэдий ч сургуулийнхаа эрсдэлийн үнэлгээг хийж, өөрийн сургуулийн онцлогт нийцүүлэлгүй жишиг бодлогыг шууд баталсан.

Үнэлгээнд хамрагдсан сургуулиудиа ХХБ-той уялдуулж баримт бичиг баталсан сайн жишээг дурдвал:

- 1. Дорнод-Гурван загал:** Хувийн нууцыг чандлан хадгалах загварыг сургуулийнхаа нөхцөл байдалд уялдуулан гаргасан байна.
- 2. Завхан аймаг Жавхлант сургууль** ХХБ-ын хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэмд эмч холбон зуучилна гэж хариуцах эзнийг тодотгож өгсөн
- 3. Багануур ГГЦС** Сургуулийн дүрмийн нийтлэг үндэслэлийн 1.5-д хүүхдэд ээлтэй, 1.6-д хүүхдийн аюулгүй байдлыг, 2.2.4-д сургуулийн захирал хүүхэд

---

хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх журам батална, 2.7-д Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрүүдийг ялангуяа жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамгаалах, 2.11-д суралцагчийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх гэсэн тодорхой заалтуудыг суулгаж өгсөн байна.

**4. Боловсрол цогцолбор сургууль:** Хөдөлмөрийн дотоод журмын Ажилтны эрх үүрэг буюу 10.6 дахь хэсэгт “Сургуулийн удирдлага болон бусад багш, ажилтан, суралцагчид өөр хоорондоо сэтгэл санаа, эд материал, бие махбодын дарамт, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтыг оруулсан нь тус тус сайшаалтай байна.

**Сул тал:** Зарим сургууль ХХБ-д зайлшгүй байх дараах заалтуудыг хасаж баталсан байна. Үүнд:

1. Сургуулийн орчинд Хүүхдэд ээлтэй нийгэм Сэтгэл зүйн харилцааны орчин бий болгоход нөлөөллийн ажлыг суралцагчдын оролцоотой зохион байгуулж аливаа дарамтгүй болох
2. Зүй бус хандлагыг үл тэвчих соёлыг бий болгох
3. Багшийн ёс зүйн дүрмийн заалтуудыг ... хүлээн зөвшөөрсөн гарын үсгийг зуруулж даган мөрдөхөд хяналт тавих гэх мэтчилэн бодлогын чухал заалтууд
4. Зорилт 3-ын мэргэжлийн байгууллагаас туслалцаа авах, хохирогч хүүхдийг холбон зуучлах үйл ажиллагааг сургуулийн захирал зохион байгуулна, сургууль, дотуур байрны үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах, бодлого боловсруулахад эцэг эхийн зөвлөл, олон нийтийг татан оролцуулах байнгын дэмжлэг, түншлэл бий болгох,
5. Удирдлага зохион байгуулалтын Боловсролын хэлтэстэй холбоотой заалтууд,
6. Хүрэх үр дүнгийн сургууль дотуур байранд хүүхдийг сурч амьдрахад эрүүл аюулгүй таатай хамгаалагдсан орчин бүрдэнэ гэсэн заалтуудыг хасаж баталжээ.

Сургуулиуд Хүчирхийлэл ялгаварлан гадуурхалтад өртсөн асуудал гарвал ямар үйлчилгээг нэн тэргүүнд үзүүлэх, хаана хэнд хандах, зөрчил үйлдэгчид хэрхэн хариуцлага хүлээлгэх талаар огт дурдаагүй байна. Мөн иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийг хүргэх, санал хүсэлтийг авах арга зам нь тодорхой тусгагдаагүй байна. Сургуулийн дүрмийн 5-р зүйлд “Эцэг эх асран хамгаалагчийн эрх үүрэг” хэсэгт Сургуулийн үйл ажиллагаа, багш ажилтнуудын харилцаа хандлага, ёс зүй, үйлчилгээний болон өөрийн хүүхэдтэй холбоотой асуудлаар санал хүсэлт гаргах эрхтэй гэж заасан ч ямар зөрчил, асуудлыг сургуулийн захиргаа, анги удирдсан багш, эцэг эхийн зөвлөлөөр тус бүрд нь шийдвэрлүүлэхийг дурьдаагүй, шийдвэрлэх хугацаагүй, шийдвэрлэсэн хариуг хэрхэн яаж авах, шийдвэрт гомдол гаргах тухай заагаагүй, хориглох заалтууд оруулсан ч зөрчвөл хэн ямар арга хэмжээ авах талаар заалт байхгүй,

**Ерөнхий боловсролын сургуулийн дүрмийн 3.7.4.1 дэх хэсэгт** “Суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрийг нь хүндэтгэн хамгаалах, суралцагч бүрийн онцлог байдлыг нь хүлээн зөвшөөрч хүнлэг харьцах, өөрөө өөрийгөө хөгжүүлэх, бие хүн болгож төлөвшихөд туслалцаа үзүүлэх суралцагчийн бие даасан байр суурь үзэл бодолд хүндэтгэлтэй хандана”. гэсэн заалт байгаа ч сургуулиудын хүүхэд хамгааллын бодлоготой уялдуулан тодорхой чиглэл тусгагдаагүй байна. Зарим нэг сургууль Сурагчийн ёс зүйн андгайн 4.7 д ёс зүйн доголдол гаргасан бол сануулах, донгодох, хөөх арга хэмжээг оруулсан байна. Сургуулиас хөөх арга хэмжээ төлөвлөж байгаа нь хүүхдийн эрхийн суурь зарчмаа зөрчиж байна гэж үзэхэд хүргэж байна.


## ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

ХХБ-ын хэрэгжилтийг бодлогын 3 зорилтын хүрээнд үнэлэхэд дараах үр дүн гарлаа.

“Сургууль, дотуур байранд хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй, материаллаг болон нийгэм, сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг ханган ажиллана” гэсэн 1 дүгээр зорилтын хүрээнд:

Суралцагч, эцэг эх, багш нар “Эрүүл аюулгүй орчин”, “Үл хайхрах”, “Дарамт” гэдгийг хэрхэн ойлгож байгааг асуулгаар тодорхойлохыг зорьсон.

**График 11.** Эрүүл аюулгүй орчныг тодорхойлсон нь




“Эрүүл аюулгүй орчин” гэдгийг юу гэж ойлгож байна вэ? гэсэн асуултад эцэг эх, багш, суралцагчдын талаас илүү нь “Тав тухтай сургалтын байр, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан анги танхимтай сургуулийг хэлнэ.” гэсэн хариултыг сонгосон байгаа нь сургуулийн материаллаг орчин тааруу байгааг илэрхийлж байна.

Мөн суралцагчдын тал орчим хувь нь “Автомашин цөөтэй, хүүхэд гэртээ ирж очихдоо тайван, аюулгүй зорчих газрыг хэлнэ” гэсэн хариултыг сонгосон байгаа нь суралцагчид аюулгүй зорчих боломжийг хүсэж байгааг илтгэж байна.

Оролцогчид “Хүүхэд бүрийг хүндэтгэн харьцдаг, онцлогт нь тохируулж сургаж, хөгжүүлдэг газрыг хэлнэ”, “Хэн нэгнээс айлгүй өөрийн үзэл бодлоо илэрхийлэх нөхцөл боломж бүрдсэн газрыг хэлнэ”, “Аливаа халдлага, дарамтанд өртөхгүй байх газрыг хэлнэ” гэж хариултыг түлхүү сонгосон байна.

Энэ асуултад нийт 9 боломжит хариулт өгсөн ба судалгаанд оролцогч эцэг эх, багш, суралцагчид өөр өөр хариулт сонгох хандлагатай байгаа нь “Эрүүл аюулгүй орчин” гэдэг ойлголтыг юу гэж тодорхойлох нэгдсэн ойлголтод хүрээгүй байгааг харуулж байна.

**График 12.** Эрүүл аюулгүй орчны талаарх ойлголт



Эрүүл аюулгүй орчин гэдгийг юу гэж ойлгож байна вэ? гэсэн асуултад 9 хариулт өгөгдсөнөөс 1 хариулт сонгосон эцэг эх 28%, багш 22%, суралцагч 38% байгаа бол 3 хариулт сонгосон эцэг эхийн 13% ,багш нарын 16%, суралцагчийн 12%




байна. Эндээс харахад судалгаанд оролцогч талуудын талаас илүү хувь нь нэгдсэн ойлголтод хүрээгүй, ойлголтын зөрүү их байгаа нь харагдаж байна.

**График 13.** “Үл хайхрах” гэдгийг тодорхойлсон нь




“Үл хайхрах” гэдгийг юу гэж ойлгож байна вэ? тохирох бүх хариултыг сонгоно уу гэх асуултад эцэг эхийн 62.2%, багш нарын 71.3%, суралцагчдын 50.9% нь “Хүүхдийн санаа бодлыг сонсохгүй, хүлээн авахгүй байхыг ойлгоно” гэсэн бол эцэг эхийн 62.9%, багш нарын 62.8%, суралцагчдын 52.9% нь “Хүүхэд хичээж, чармайлт гаргасан ч урамшуулж, дэмждэггүй байхыг хэлнэ” гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдоос хамгийн бага саналыг “Өлсөх, даарах, халууцах зэрэг гадаад орчин нөхцөлөөс болж хичээлдээ төвлөрч чадахгүй, суралцах орчин бүрдэхгүй байгааг ойлгоно” гэсэн хариулт өгсөн байна. Талуудын 50%-иас илүү нь 7 хариултын хоёр хариултад санал өгсөнөөс харахад “Үл хайхрах” гэдгийг оролцогч талууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хүүхдийн сэтгэл санаатай хамааралтай ойлголт гэж үзэж байна.

**График 14.** Үл хайхрах ойлголт



“Үл хайхрах” гэдгийг юу гэж ойлгож байна вэ? гэх асуултад 7 хариулт өгөгдсөн бөгөөд судалгаанд оролцогчдын олонх нь 1-3 хариулт сонгосон байна. Үүнээс эцэг эхийн 31%, багш нарын 24%, суралцагчдын 44% нь нэг хариултыг сонгосон бол 3 хариултыг эцэг эхийн 16%, багш нарын 23%, суралцагчдын 15% нь сонгосон байна.


**График 15.** Дарамт гэдгийг тодорхойлсон нь



“Дарамт” гэдгийг эцэг эхчүүдийн 66.3%, багш нарын 63.6%, суралцагчдын 66.7% нь “Сургуулийн орчинд хүүхдийг түлхэж, мөргөх, зодох, цохих, бүлэглэн дээрэлхэхийг хэлнэ” гэсэн бол “Хүүхдэд нэр хоч өгөх, шоглох, тохуурхан доромжлохыг хэлнэ” гэж эцэг эхчүүдийн 60.5%, багш нарын 62.6%, суралцагчдын 53.3% нь сонгосон байна. Асуулгын дээрх хоёр хариулт хамгийн өндөр санал авсан бол хамгийн бага саналыг буюу эцэг эхчүүдийн 11.1%, багш нарын 10.7%, суралцагчдын 10.2% нь “Эцэг эхийг дуудаж, уулзаж хүүхдийн гаргасан алдааг хэлэхийг ойлгоно” гэсэн хариултад санал өгчээ.

Оролцогч талуудын талаас илүү хувь нь “Дарамт” гэдгийг бие махбодийн болон аливаа хэлбэрээр үг хэлээр доромжлох, гутаах гэдэгт санал өгсөн байна.


**График 16.** Дарамтын талаарх ойлголт



Дарамт гэдгийг юу гэж ойлгож байна вэ? гэх асуултад нийт 11 хариулт өгсөн ба эцэг эхчүүдийн 25%, багш нарын 18%, суралцагчдын 35% нь 1 хариулт сонгосон бол 2 хариултыг оролцогч талууд бүгд 11% байна. Багш нарын олонхи буюу 22% нь 8 хариултыг сонгож, 9, 10, 11 хариулт сонгоогүй байна.


Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангасан эсэхийг суралцагчид дараах байдлаар үнэлж байна.

**График 17.** Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангасан эсэх (1)




Суралцагчдын талаас илүү хувь нь өгөгдсөн сонголтуудаас “Санал нийлж байна”, “Санал маш их нийлж байна” гэсэн хариулт өгсөн боловч 10 суралцагч тутмын нэг нь сургуульдаа явах дургүй юм уу, дуртай эсэхээ мэдэхгүй, 2 хүүхэд тутмын нэг нь хүний эрхийн талаарх мэдлэг, эрхээ хамгаалж чадах эсэх талаараа сайн мэдэхгүй гэж хариулсан байгаа нь өндөр үзүүлэлт учир анхаарах шаардлагатай.

**График 18.** Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангасан эсэх (2)




3 хүүхэд тутмын 2 нь ковидын улмаас гэртээ байх хугацаандаа хичээлээ сайн хийж чадаагүй эсвэл чадсан эсэхээ мэдэхгүй байна. Хичээлээ ойлгоогүй хоцорсон бол сэтгэлээр их унадаг гэж 63.3% нь хариулсан.

**График 19.** Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангасан эсэх (3)



Дээрх хариултуудаас харахад 3 хүүхэд тутмын нэг нь “мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн нь сургууль суралцагчдын хувьд аюулгүй орчин байж чадахгүй байна. Мөн сургуулийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тухай айдасгүй мэдээлж чадахгүй, мэдэхгүй гэж 73.9% нь хариулсныг анхаарч үзэх хэрэгтэй.

**График 20.** Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангасан эсэх (4)




10 хүүхэд тутмын 2-3 нь багштай холбоотой асуултад сайн мэдэхгүй гэж хариулж байгаа нь анхаарал татаж байна. 2 хүүхэд тутмын 1 нь багшийн хандлага таагүй, дарамттай санагддагаас хичээлдээ оролцох идэвхгүй болдог гэж хариулсан. Багшийн хандлагаас шалтгаалан хүүхдүүдийн бие биетэйгээ харилцах хандлагад өөрчлөлт ордог гэж 2 хүүхэд тутмын 1 нь хариулсаныг анхаарах шаардлагатай.

**График 21.** Сургуулийн ажилчдаас тусламж авч чаддаг эсэх



Суралцагчдын гуравны хоёр нь сургуулийн орчинд дарамтанд өртсөн бол сургуулийн ажилчдаас тусламж авч чаддаг гэж хариулсан байна.


**График 22.** Суралцагчид сургуулийн орчинд зодож, зодуулж байсан эсэх




Сургуулийн орчинд 10 суралцагч тутмын 2 нь нэгээс дээш удаа ямар нэгэн байдлаар зодож, зодуулдаг гэж хариулсан бөгөөд байнга болон бүлэглэж зодох асуудал байсаар байна.

Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдэж, хүүхдийн эрх хангагдаж байгаа эсэх талаар багш, эцэг эхчүүд хүүхдүүдтэй ярилцдаг эсэхийг тодрууллаа.

**График 23.** Гэрт болон сургууль дээр тохиолдсон сайхан зүйлсийн ганцаарчлан ярилцдаг эсэх




**График 24.** Ямар давтамжтай ярилцдаг




Багш, эцэг эхчүүдийн 80 гаруй хувьд нь хүүхдүүдтэйгээ тохиолдсон сайхан зүйлсийн талаар ярилцдаг бөгөөд эцэг эхчүүдийн олонх буюу 42% нь өдөр бүр, харин багш нарын олонх буюу 35% нь сардаа нэг ярилцдаг гэжээ.

**График 25.** Таагүй явдлын талаар ярилцдаг эсэх




**График 26.** Ямар давтамжтай ярилцдаг



Хүүхдүүдтэйгээ тохиолдсон таагүй үйл явдлуудын талаар эцэг эх, багш нарын 70 гаруй хувь нь ярилцдаг гэж хариулсан байгаа нь сайшаалтай. Эцэг эхчүүдийн олонх нь буюу 36% нь өдөр бүр, багш нарын олонх нь буюу 31% нь сард 1 удаа тохиолдсон таагүй явдлуудын талаар ярилцдаг гэсэн хариулт өгсөн.

Багш нарын 19.3% нь бусад хариултыг сонгосны ихэнх нь “асуудал гарвал тухай бүрт”, “Шаардлагатай үедээ ярилцдаг” гэсэн хариулт байна.


**График 27.** Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж буй, өртөж болзошгүй нөхцөлтэй таарвал та ямар нэгэн айдасгүйгээр шууд мэдээлэх эсэх



Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж буй, өртөж болзошгүй нөхцөлтэй таарвал ямар нэгэн айдасгүйгээр шууд мэдээлэх үү? гэсэн асуултад багш, эцэг эхчүүдийн 60 гаруй хувь нь “Шууд мэдээлнэ” гэж хариулсан.

Гэвч багш нарын 22%, эцэг эхчүүдийн 16% нь мэдээлэл задрахаас айна гэсэн хариулт өгсөн байгаа нь хүүхэд хамгааллын бодлогыг сургуулийн онцлогт тохируулан боловсруулаагүй, мэдээлэл хүлээн авах, мэдээллийн нууцлалыг хадгалах зэрэг процессыг тодорхой болгоогүй гэсэн баримт бичгийн шинжилгээний дүгнэлттэй нийцэж байна.


**График 27.** Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж буй, өртөж болзошгүй тохиолдлыг та ямар хэлбэрээр мэдээлэх вэ?



Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж буй, өртөж болзошгүй тохиолдлыг эцэг эхчүүдийн ихэнх нь буюу 54.3% “Утсаар”, багш нарын ихэнх нь буюу 52.3% нь “Биечлэн мэдээлнэ” гэсэн байна.




**График 28.** Сургуульд санал хүсэлтийн хайрцаг байдаг эсэх




Сургуульд санал хүсэлтийн хайрцаг байдаг уу? гэсэн асуултад багш нарын 61%, эцэг эхчүүдийн 40% байдаг гэсэн хариулт өгчээ. Харин багш нарын 18%, эцэг эхчүүдийн 43% нь “Мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн бөгөөд эцэг эхчүүд цар тахлын улмаас сургууль руу орж чадаагүй, хүүхэд нь шинээр шилжиж очсон, анзаарч байгаагүй зэрэг шалтгаануудыг тоочиж байсан.

**График 29.** Хүүхдийнхээ сургуульд явах замыг аюулгүй гэдэгт итгэлтэй байдаг эсэх



Багш нарын 54.4%, эцэг эхчүүдийн 64% хүүхдийнхээ сургуульдаа ирэх, очих замыг “Аюулгүй гэдэгт итгэлтэй байдаг” гэсэн хариулт өгсөн. Нөгөөтэйгүүр багш нарын 45.6%, эцэг эхчүүдийн 36% нь ирж очих замыг “Аюултай” гэж үзсэн бөгөөд “Зам тээврийн осол, нохой, согтуу хүн, гэрэлгүй гудамж, хол зам” гэсэн эрсдэлүүдийг давхардуулан тоочсон байгаа нь хүүхдүүд сургуульдаа ирж, очиход аюул байсаар байгааг харуулж байна.

**График 30.** Хүүхэд тань сэтгэл амар тайван, таатай орчинд сурдаг эсэх



Багш нарын 81.3%, эцэг эхчүүдийн 88.7% нь хүүхдээ сэтгэл амар тайван, таатай орчинд сурдаг гэдэгт итгэлтэй байдаг гэсэн хариулт өгсөн байгаа нь багш эцэг эхчүүдийн дийлэнх олонх нь сургууль дотроо хүүхэд аюулгүй байна гэж үзэж байна.

**Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийн хангахын тулд сургуульд хийх өөрчлөлтийн талаар оролцогчид дараах саналыг дэвшүүлж байна.**

Суралцагчид сургуулийн орчин, соёл, сургалтын чанартай холбоотой өөрчлөлт хийхийг хүсэж байна.<sup>1</sup>

Сургуулийн байр, орчин:

1. Материаллаг эд зүйлс (ангиа томруулах, тохижуулах, сандал ширээ шинэчлэх, агааржуулагч, шүүгээ гэх мэт) орчинтой холбоотой
2. Чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж, өөрийгөө хөгжүүлэх нэмэлт сургалтууд (гадаад хэл, урлаг, спорт, мэргэжлийн чиг баримжаа олгох дугуйлан, клуб), тэдгээрийг зохион байгуулах анги танхим, үеийнхэнтэйгээ цагийг зөв боловсон өнгөрүүлэх, цагийг үр бүтээлтэй, хамтран өнгөрүүлэх боломж
3. Үдийн цай/хоол өгдөг болох эсвэл цайны газартай болох, цайны газрын үйлчилгээг хүртээмжтэй болгох
4. Бие заах газраа хүртээмжтэй болгох, цэвэрхэн байлгах, хаалгатай, цоожтой, тасалгаатай, эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөг тусад нь байршуулах, 00-ын цаас, гарын савантай байх
5. Гадаах орчны аюулгүй байдал, сургуулийн орчинд машин оруулахгүй байх, гарц гарам, аюулгүй тэмдэг тэмдэглэгээ байршуулах, ногоон байгууламж (эцэг эхээ хүлээх аюулгүй таатай орчин)

Сургуулийн соёл:

<sup>1</sup> Нийт 4194 хариулт бичсэн, үүнээс 6-р ангийн хариулт 933, 7-р анги 1000, 8-р анги 1015, 9-р анги 1246. Эмэгтэй - 2792 хариулт, Эрэгтэй - 1402 хариулт ирүүлсэн.

1. Багш, ажилчдын харилцаа хандлагыг сайжруулах, хүүхдийг ялгаж харилцахгүй байх
2. Сургуулийн орчинг ялгаварлан гадуурхах, дарамт, хүчирхийлэлгүй болгох
3. Суралцагчдын харилцаа, хандлагыг өөрчлөх буюу үе тэнгийн дарамт дээрэлхэлтгүй, бие биетэйгээ соёлтой боловсон харилцаж хувийн орон зайг хүндэтгэх
4. Хувцаслалт, үс засалтаар ижилсэхгүй хүссэн хувцсаа өмсөж, хүссэнээрээ үсээ засуулах

Сургалтын чанар:


1. Хичээлийг үр бүтээлтэй, сонирхолтой заах, суралцагч бүрийн онцгой хэрэгцээг харгалзан ойлгуулахын тулд хичээлээ заах, нэг багшид ногдох суралцагчдын тоог багасгах, хичээлийн бусад цагаар сонирхсон хичээлийг гүнзгийрүүлэн үзэх зэрэг өөрчлөлтийг дурдсан

Бусад гэдэгт сургуулийн автобустай болох, сэтгэл зүйчтэй болох, чадварлаг эмчтэй болох гэх мэт өөрчлөлт дурдагдсан.

**Хүснэгт 5.** Сургуульд хийх өөрчлөлтийн талаар суралцагчдын хариулт /анги, хүйсээр/

| № | Сургуульд хийх өөрчлөлт                   | 6 эм | 6 эр | 7 эм | 7 эр | 8 эм | 8 эр | 9 эм | 9 эр | Нийт | Хувь |
|---|---|------|------|------|------|------|------|------|------|------|------|
| 1 | Сургуулийн байр/Орчин                     | 289  | 167  | 336  | 187  | 407  | 173  | 487  | 211  | 2257 |      |
|   | Чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж, орчин     | 45   | 13   | 52   | 31   | 63   | 17   | 100  | 32   | 353  |      |
| А | Цайны газар/Хоол                          | 40   | 25   | 43   | 23   | 41   | 17   | 63   | 30   | 282  |      |
| Б | Бие засах газар                           | 36   | 24   | 51   | 14   | 48   | 16   | 42   | 12   | 243  |      |
| В | Заал талбай                               | 6    | 12   | 27   | 26   | 33   | 37   | 56   | 44   | 241  |      |
| Г | Сургуулийн гадаах орчны аюулгүй байдал    | 36   | 24   | 48   | 28   | 13   | 7    | 17   | 13   | 186  |      |
| Д | Номын сан, ном                            | 24   | 5    | 22   | 11   | 19   | 5    | 41   | 4    | 131  |      |
| 2 | Сургуулийн соёл                           | 132  | 79   | 157  | 81   | 170  | 60   | 186  | 85   | 950  |      |
| А | Багш ажилчдын харилцаа, хандлага          | 31   | 13   | 39   | 18   | 49   | 14   | 58   | 19   | 241  |      |
| Б | Ялгаварлан гадуурхах, дарамт, хүчирхийлэл | 19   | 26   | 36   | 26   | 16   | 10   | 32   | 9    | 174  |      |
| В | Суралцагчдын харилцаа, хандлага           | 25   | 10   | 31   | 23   | 35   | 10   | 20   | 5    | 159  |      |
| Г | Хувцаслалт                                | 9    | 1    | 15   | 4    | 27   | 8    | 24   | 6    | 94   |      |
| 3 | Сургалтын чанар, агуулга, хэрэгсэл        | 46   | 44   | 63   | 41   | 61   | 27   | 92   | 36   | 410  |      |
| 4 | Мэдэхгүй/байхгүй                          | 57   | 31   | 56   | 37   | 46   | 33   | 62   | 53   | 375  |      |
| 5 | Бусад                                     | 50   | 38   | 33   | 9    | 33   | 5    | 29   | 10   | 257  |      |

**График 31.** Сургууль эрүүл аюулгүй байхын тулд хийх зүйлс




Багш нарын өгсөн хариултаас “Ээлтэй цэвэр орчин/ анги танхим цэвэр байгаасай, ногоон байгууламж их”, “Сургуулийн соёл, дүрэм журам (бүтээлч үйл ажиллагаанууд хийх)”, “Багш, удирдлага, ажилчдын ур чадвар, хандлагыг сайжруулах (хүүхдүүдэд анхаарч ажиллах, сонсох) гэсэн өөрчлөлт хийхийг хүссэн бол Эцэг эхчүүд “Сургуулийн гадаах орчин, аюулгүй байдал, сургалтын чанар, агуулгатай холбоотой” саналууд, “Эцэг эхчүүдэд мэдээлэл, сургалт өгөх” гэсэн саналууд өгсөн байна. Эцэг эхчүүдийн 14% нь мэдэхгүй, байхгүй гэсэн хариулт өгсөн нь анхаарал татлаа.

## СЭТГЭЛ ХАНАМЖ

Сургуулийн орчинд хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд оролцогч талууд сэтгэл ханамжтай байгаа эсэхийг тодрууллаа.


**График 32.** Сургуулиас хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг эхчүүдэд зориулсан үйл ажиллагаануудад сэтгэл хангалуун байдаг эсэх



5 эцэг эх тутмын нэг нь сургуулиас зохион байгуулсан үйл ажиллагаанд сэтгэл хангалуун оролцдог гэсэн хариулт өгсөн. Харин сонирхолтой үйл ажиллагаа зохион байгуулбал оролцоно гэж 3 эцэг эх тутмын нэг нь хариулсан байна.


3 багш тутмын нэг нь сэтгэл хангалуун оролцдог, сонирхолтой үйл ажиллагаа зохион байгуулбал оролцоно гэсэн хариулт өгсөн байна.

**График 33.** Хүүхэд хамгааллын бодлоготой болсноор сургуулийн орчин аюулгүй болсон эсэх




Эцэг эхчүүдийн тал нь сургуулийн ХХБ-той болсноор сургуулийн орчин илүү аюулгүй болсон гэж үзэж байна. Багш нарын 65.6% нь эцэг эхчүүдтэй санал нийлж байна.

**График 34.** Хүүхэд хамгааллын бодлоготой болсноор сургуулийн орчин өөрчлөгдсөн эсэх



ХХБ-той болсноор сургуулийн орчин сайжирч байгаа гэж багш, эцэг эхчүүдийн дийлэнх нь үзэж байгаа ч эцэг эхчүүдийн 30% нь огт өөрчлөлт гаргаагүй гэж үзэж байна.

**График 35.** Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд хийгдсэн ажлын үр дүнд ямар нэгэн эерэг өөрчлөлт гарсан эсэх



Сургуулийн орчинд суралцагчдад учирч болох эрсдэлийг багасгах ажилд оролцсоны үр дүнд өөрчлөлт гарсан эсэхийг асуухад багш нарын тал орчим хувь нь зарим нэг зүйл сайжирсан гэж үзсэн бол эцэг эхчүүдийн тал нь мэдэхгүй байна. Энэ нь үнэлгээний явцад удаа дараа гарч буй асуудал болох сургуулийн удирдлагын зүгээс эцэг эхийн оролцоог бүрэн хангаж чадаагүй, ХХБ-той болсноор хангалттай өөрчлөлт гараагүй байгааг харуулж байна.

## ДОТУУР БАЙР

Ганцаарчилсан ярилцлагын **ХХБд дотуур байрны хүүхэд хамгааллын асуудлыг хэрхэн тусгасан бэ?** гэсэн асуултад дараах хариултыг өгсөн.

- Захирлууд дотуур байрны асуудлыг ХХБ-д хэрхэн тусгасан талаар огт хариулаагүй. Харин эрүүл, аюулгүй материаллаг орчин бүрдүүлэх, нийгэм-сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, хүүхдийн бие бялдрын эрүүл байдал зэрэг асуудлыг тусгасан гэж хариулсан байна. Хүүхэд хамгааллын баг, дотуур байрны багш, суралцагчийн саналыг тусгасан гэж хариулж байгаа боловч үүнийг нотлох баримт байхгүй байна.
- Нийгмийн ажилтны хувьд эрсдэлийн үнэлгээ хийж, суралцагч бүрээс санал асуулга, дотуур байрны багш, эцэг эхийн төлөөллөөс санал авч, хэлэлцүүлэг хийж, тулгамдаж буй асуудлыг сургуулийн хүүхэд хамгааллын бодлогод тусгуулсан гэх боловч нотлох баримт ирүүлээгүй.
- Дотуур байрны багш нараас нэг нь л “Хүүхэд хамгааллын баг дотуур байрны хүүхдүүдийн талаар сайн ярилцаж тусгасан” гэж хариулсан бөгөөд бусад нь энэ талаар огт дурдаагүй. Мөн нэг багш “дотуур байрны багшийн ёс зүй, үүрэг оролцоог тусгасан” гэж хариулсан. Бусад нь хариулаагүй эсвэл хамааралгүй хариулт өгсөн.


Сургууль тус бүрээр оролцогчдын хариултыг харахад, захирал, нийгмийн ажилтан, дотуур байрны багш гэсэн 3 бүлгийн төлөөллийн хариулт өөр өөр байгаа нь дотуур байрны асуудлыг ХХБ-д хэрхэн тусгасан нь тодорхойгүй, орхигдуулсан нь харагдаж байна. Аливаа эрсдэлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар тусгасан гэж байгаа боловч эрсдэл, аюул, хүчирхийлэлд хүүхэд өртсөн, өртсөн байж болзошгүй тохиолдолд мэдээллийг хүлээн авах, хариу үйлчилгээ үзүүлэх, хохирогч хүүхдэд боловсролын үйлчилгээг тасралтгүй олгон, хүүхэд хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах талаар огт дурдаагүй байна.

Дотуур байрны багшийн хариултад дотуур байранд амьдардаг хүүхдүүдээс санал авсан сайн жишээ байна. Гэвч нийгмийн ажилтнууд дотуур байрны асуудлыг нийтлэг хариулаагүй. Эндээс нийгмийн ажилтнууд дотуур байрны асуудалд төдийлөн анхаарахгүй, энэ асуудлыг дотуур байрны багшид даатган орхиж байгаа нь ажиглагдаж байна.

Баримт бичгийн дүн шинжилгээнээс харахад сургуулийн ХХБ-д “дотуур байрны ХХБ хэрэгжүүлнэ” гэж зааснаас өөрөөр дотуур байрны асуудлыг ХХБ-д огт тусгаагүй байна.


## Дотуур байранд амьдардаг суралцагчдаас дотуур байрны нөхцөл, орчны талаарх асуулгын үр дүн:

**График 36.** Дотуур байрны орчин нөхцөл



Дотуур байрны орчин нөхцөлтэй холбоотой асуултад нийт хүүхдийн 22-36% нь сайн мэдэхгүй гэж хариулсан бөгөөд 20% хувьд нь сөрөг хариулт өгсөн байгаа нь дотуур байранд амьдрах нөхцөл тааруу байгааг харуулж байна. Суралцагчдын 27% нь дотуур байрандаа амьдрах дургүй гэсэн хариулт өгсөн байгааг онцолж байна.


**График 37.** Өрөөндөө хичээлээ хийх хүрэлцээтэй ширээ, сандалтай эсэх






Дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн 54% нь ямар нэгэн байдлаар хичээлээ хийх сандал ширээ хүрэлцээгүй эсвэл тохиромжгүй, харин үлдсэн 46% нь хүрэлцээтэй, биед тохирсон ширээ, сандалтай гэсэн хариулт өгсөн байна.

**График 38.** Өрөөний цонх нь хөшигтэй эсэх




Өрөөний цонх нь хөшигтэй эсэх асуултад суралцагчдын 79% нь “Хөшигтэй” гэж хариулсан бол “Хөшиггүй” гэж 17%, “Эвдэрхий” гэж 4% нь хариулсан байна.

**График 39.** Өрөөний хаалга түгжээтэй эсэх



Өрөөний хаалга нь түгжээтэй юу гэсэн асуултад охидын 77% нь “Түгжээтэй”, 22% нь түгжээгүй болон эвдэрхий гэж хариулсан байна. Хөвгүүдийн 54% нь “Түгжээтэй”, 36% нь түгжээгүй болон эвдэрхий гэсэн хариулт өгсөн байна.

**График 40.** Эргэн тойрон гэрэлтүүлэгтэй эсэх



Асуулгад оролцсон охидын 64%, хөвгүүдийн 59% нь дотуур байрны эргэн тойронд сайн гэрэлтүүлэгтэй гэсэн бол охидын 32%, хөвгүүдийн 41% нь ганцхан үүдэндээ, муу гэрэлтүүлэгтэй, огт гэрэлтүүлэггүй гэж хариулсан байна.

**График 41.** Гаднаа камертай эсэх



59% нь дотуур байрны гадна камертай, 41% нь камертай боловч ажилладаггүй эсвэл камергүй гэж хариулсан.

**График 42.** Бие засах газрын байрлал




57% нь дотуур байран дотроо бие засах газартай, 43% нь гаднаа гэж хариулсан.

**График 43.** Бие засах газар гадаа байрладаг бол хүндрэл байдаг эсэх



Гадна байрладаг бие засах газрын хувьд суралцагчид хаалгагүй, хаалга нь түгжээгүй, хүйсээр тусгаарлаагүй зэрэг ямар нэгэн хүндрэлтэй гэж хариулсан бол 4% нь гадна бие засах газартай холбоотой ямар нэгэн хүндрэл байхгүй гэж хариулсан.


**График 44.** Бие засах газар дотор байрладаг бол хүндрэл байдаг эсэх



Суралцагчдын 30% нь дотор байрладаг бие засах газар ямар нэгэн хүндрэлгүй гэж хариулсан бол 15% нь хүйсээр тусгаарлаагүй, 12% байнга бохир байдаг,


10% нь ариун цэврийн цаас байдаггүй гэж хариулсан байна.

**График 45.** Дотуур байранд чөлөөт цагаа өнгөрүүлэх өрөө байдаг эсэх




Суралцагчдын 44% нь чөлөөт цагаа өнгөрүүлэх өрөөтэй гэж хариулсан бол 56% нь өрөөтэй боловч ашигладаггүй эсвэл өрөө байхгүй гэж хариулсан байна.

**График 46.** Өрөөтэй бол хэрхэн ашигладаг вэ?




Дотуур байрандаа чөлөөтэй ашигладаг өрөөтэй гэж хариулсан суралцагчдын 31% нь хичээлээ давтах, 35% нь тоглох (шатар, даам, бусад), 22% нь дуу, бүжиг, хөгжим тоглох зориулалтаар ашигладаг гэж хариулсан байна.

**График 47.** Дотуур байранд гадны хүн байралдаг эсэх




6% нь дотуур байранд гадны хүн байрладаг гэж хариулсан бол 28% нь мэдэхгүй, 66% нь байрладаггүй гэж хариулсан.

**График 48.** Дотуур байранд дурдсан зүйлс байдаг эсэх



Дотуур байранд амьдардаг суралцагчдын 28% нь яаралтай үед ашиглах утас, анхны тусламжийн хайрцаг, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ аль нь ч байхгүй гэж хариулсан байна.

**График 49.** Дотуур байрны багш нар ямар үйл ажиллагаа зохион байгуулдаг вэ?




Дотуур байрны багш давтлага өгөх, сургалт, уралдаан зохион байгуулах үйл ажиллагаа зохион байгуулдаг гэж хариулсан байна.

**График 50.** Дотуур байрны багш нар хүүхэд хамгааллын ямар үйл ажиллагаа зохион байгуулдаг вэ?




Дотуур байрны багш нар “хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг” гэж дийлэнх нь хариулсан байна. Мөн “хүүхдийн хэрэгцээ тодорхойлох судалгаа авдаг” (14%), “хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар гаргасан хүүхдийн санал, гомдлыг шийдвэрлэдэг” (13%) гэж хариулсан.

**График 51.** Дотуур байранд хүүхэд хамгааллын үйл ажиллагаа төлөвлөхдөө чиний саналыг хэрхэн авдаг вэ?




Дотуур байранд хүүхэд хамгааллын үйл ажиллагаа төлөвлөхөд “хурал, уулзалт, санал асуулгаар дамжуулан санал авдаг” гэж дийлэнх нь хариулжээ. Харин 13% нь санал огт авдаггүй гэсэн байна.

**График 51.** Өөрт тулгарсан асуудлаа дотуур байрны багштайгаа ярилцдаг эсэх




Суралцагчдын 66% нь өөрт тулгарсан асуудлын талаар дотуур байрны багштайгаа ярилцдаг гэсэн бол 34% ярилцдаггүй гэж хариулсан байна. Яагаад дотуур байрны багштайгаа асуудлаа ярилцдаггүй талаар тодруулахад “Зүгээр хэлээд өнгөрдөг, асуудал шийдвэрлэдэггүй”, “Багш завгүй байна гэдэг”, “Багшаасаа айдаг”, “Бусдад хэлчихвийдээ гэж эмээдэг”, “Багшид хүндрэлтэй”, “Заримдаа тоодоггүй” гэж хариулжээ.

**График 52.** Тийм бол асуудлаа шийдэхэд тусалдаг эсэх




Дотуур байрны багшдаа өөрт тулгарсан асуудлаа хэлэхэд асуудлыг шийдвэрлэдэг гэж суралцагчдын 72% нь хариулсан бол 28% нь үгүй гэж хариулсан бөгөөд яагаад гэдгийг тодруулахад “Тусалдаг боловч асуудлыг сайн шийдэж чаддаггүй”, “Сонсдоггүй”, “Тоохгүй өнгөрдөг” гэжээ.

**График 53.** Асуудлыг шийдэхэд хэрхэн тусалсан бэ?



Дотуур байрны багш суралцагчийн асуудлыг ярилцаж, зөвлөгөө өгч шийдвэрлэсэн гэж суралцагчдын 70 орчим хувь нь хариулжээ.

**График 54.** Дотуур байрны багш таагүй ханддаг эсэх



Охидын 19%, хөвгүүдийн 29% нь дотуур байрны багш таагүй ханддаг гэж хариулсан.




**График 55.** Таагүй ханддаг бол хэрхэн ханддаг вэ?



Дотуур байрны багш таагүй ханддаг бол хэрхэн ханддаг вэ гэсэн асуултад суралцагчдын 15% нь бие махбодын шийтгэл хүлээлгэдэг, 46% нь сэтгэл санааны дарамт үзүүлдэг, 33% нь үл хайхардаг гэж хариулжээ.

**График 56.** Дотуур байрны багш нь ямар байгаасай гэж хүсдэг вэ?



Дотуур байрны багш нь ямар байгаасай гэж хүсдэг вэ гэсэн хариултад суралцагчдын 37% нь мэдэхгүй гэж хариулжээ. 24% нь ярилцдаг, 15% нь хувийн нууц сайн хадгалж зөвлөгөө өгдөг байгаасай гэж хүсэж байна.


**График 57.** Дотуур байрандаа өөрийн хүссэн 3 өөрчлөлтөө хийх боломж олдвол юуг хамгийн түрүүнд өөрчлөх вэ?



Дотуур байранд хийх өөрчлөлттэй холбоотой суралцагчдын саналыг багцалбал материаллаг орчинтой холбоотой санал 43%, соёл, харилцаа хандлагатай холбоотой санал 26% эзэлж байна.


**Дотуур байрны орчин нөхцөлийн талаар эцэг эхийн санал бодол.**

**График 58.** Таны хүүхэд дотуур байранд элдэв дарамгүйгээр амар тайван байх боломжтой эсэх




Эцэг эхчүүдийн 63% нь хүүхдээ дотуур байранд элдэв дарамтгүй, амар тайван байх боломжтой болсон гэж хариулсан бол гурван эцэг эхийн 1 нь өөрчлөлт мэдэгдээгүй гэсэн хариулт өгсөн байна.

**График 59.** Хүүхэд хамгааллын бодлоготой болсноос хойш дотуур байрны орчин сайжирсан эсэх



Эцэг эхчүүдийн 70% нь ХХБ-той болсноос хойш дотуур байрны орчин сайжирсан гэж үзэж байна.

**График 60.** Хүүхэд хамгааллын бодлоготой болсноос хойш хүүхэд тань дотуур байрандаа гарсан өөрчлөлтийн талаар ярьж байхыг сонссон эсэх



Эцэг эхчүүдийн 57% нь ХХБ-той болсноос хойш гарсан өөрчлөлтийн талаар хүүхдээсээ сонссон гэж хариулсан.

## ДҮГНЭЛТ

Хөндлөнгийн үнэлгээний ерөнхий үр дүнг хөндлөнгийн үнэлгээний хүрээнд дэвшүүлсэн дараах асуултын хүрээнд нэгтгэн гаргалаа.

- Сургуулийн ХХБ боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх үйл явцад олон талын оролцоо бүрэн хангагдсан уу?
- Сургуулийн ХХБ нь сургуулийн хэмжээнд баримталж буй баримт бичигтэй уялдсан уу?
- Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт сургуулийн түвшинд ямар байна вэ?
- Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд оролцогч болон үр шим хүртэгч талууд сэтгэл ханамжтай байна уу?

Үнэлгээний эхний асуулт болох “Сургуулийн ХХБ боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх үйл явцад олон талын оролцоо бүрэн хангагдсан уу?” гэсэн асуултын хүрээнд шинжилгээ хийж **“Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын үйл явцад олон талын оролцоо бүрэн хангагдаагүй байна”** гэж дүгнэлээ. Энэ дүгнэлтийг дараах үндэслэлээр бататгаж байна. Үүнд:

- ХХБ хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөө боловсруулахад талуудыг хэрхэн оролцуулдаг талаар оролцогчдын 75% нь хариулаагүй, үнэлгээнд хамрагдсан нэг ч сургууль ХХБ хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг үнэлгээний багт ирүүлээгүй нь сургууль ХХБ хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулдаггүй гэж дүгнэхэд хүргэж байна.
- ХХБ-ын бодлогод заасан 3 зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлд 30 гаруй үйл ажиллагааг дурдсан хэдий ч үнэлгээнд хамрагдсан сургуулиуд сургалт, хурал, тараах материал, үнэлгээ, санал авах гэсэн цөөн үйл ажиллагаагаар хязгаарлаж байна.
- ХХБ-ыг эцэг эхэд албан ёсоор таниулах ажил хангалтгүй байгаа нь эцэг эхчүүдийн талаас илүү нь танилцуулаагүй, мэдэхгүй гэж хариулснаас харагдаж байна. Түүнчлэн 3 эцэг эх тутмын нэг нь танилцуулсан ХХБ-ыг ойлгоогүй байна.
- Ярилцлага, баримт бичиг болон асуулгын үр дүн хоорондоо зөрүүтэй байна. Жишээлбэл: ХХБ-ыг хэрхэн боловсруулсан талаар ярилцлагад хамрагдсан захирлуудын 15%, нийгмийн ажилтнуудын 9% санал асуусан, захирлуудын 4% нь эцэг эх суралцагчдаас авсан судалгаанд үндэслэн, харин эцэг эхчүүдийн 4,5% нь ярилцаж гэж хариулсан бол асуулгад хариулсан эцэг эхчүүдийн 40% нь санал аваагүй гэж хариулсан.
- Ярилцлагад хамрагдсан талуудын хариулт зөрүүтэй байна. Жишээлбэл ярилцлагад хамрагдсан захирал, нийгмийн ажилтны 86% эцэг эхийг оролцуулсан гэж хариулсан бол эцэг эхчүүд оролцсон гэсэн хариулт өгөөгүй. Нийгмийн ажилтны 20% нь ХХБ-ыг ганцаараа боловсруулсан

гэсэн бол захирлууд энэ талаар дурдаагүй. Мөн захирал, нийгмийн ажилтны 50-70% олон талыг оролцуулдаг гэсэн бол эцэг эхчүүдийн хувьд энэ үзүүлэлт 20% хүрэхгүй бөгөөд энэ нь зөвхөн эцэг эх, багш, суралцагчийн гурвалсан гэрээ байгуулсныг хэлж байна.

- ХХБ-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой заалт хэрэгжихгүй байна. Ялангуяа орон нутгийн боловсролын газар хэлтэс “ХХБ-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг эцэг эхийн зөвлөлтэй хамтран жил бүр хийх” заалт үнэлгээнд хамрагдсан аль ч сургууль дээр хэрэгжээгүй.

Үнэлгээний хүрээнд дэвшүүлсэн “Сургуулийн ХХБ нь сургуулийн хэмжээнд баримталж буй баримт бичигтэй уялдааг үү?” гэсэн асуултын хүрээнд хийсэн дүн шинжилгээгээр **“Сургуулийн ХХБ нь сургуулийн хэмжээнд баримталж буй баримт бичигтэй уялдаагүй”** гэж дүгнэж байна. Энэхүү дүгнэлтийг дараах үндэслэлээр бататгаж байна. Үүнд:

1. Үнэлгээнд баримт бичгээ ирүүлсэн сургуулиудын 19 нь БШУЯ-наас батлан гаргасан жишиг бодлогыг, харин 14 нь Хүүхдийн Төлөө Үндэсний Зөвлөлийн (ХТҮЗ) жишиг бодлогыг, 2 сургууль хүүхэд хамгааллын үндэсний хөтөлбөрийг баталгаажуулан хэрэглэж байна.

- БШУЯ-ны ХХБ нь боловсролын байгууллагад зориулсан тул нарийвчилсан байдлаар боловсруулагдсан боловч дагалдах зохицуулалт байхгүй
- ХТҮЗ-ийн хүүхэд хамгааллын жишиг бодлого нь хүүхэдтэй ажилладаг байгууллагад зориулагдан ерөнхий зөвлөмж байдлаар боловсруулагдсан.

БШУЯ-наас баталсан бодлогыг баримталж ХХБ-оо боловсруулсан 19 сургууль нь ХНХС, ХЗДХС-ын хамтарсан тушаалаар баталсан \2017.07.04 А\120,А\178\ дугаар хавсралт 2-ын Хүүхэд хамгааллын үйлчилгээний багц маягтын зөвхөн Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам, Хүүхдийн эрх, хамгааллын зөрчлийн мэдээлэл хүлээн авах маягыг л бөглөн хөтлөж байна.

2. 14 сургууль Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 сарын 03 ны өдрийн 03 дугаар тогтоолын 1-р хавсралтыг үндэслэн Хүүхэд хамгааллын бодлогоо боловсруулсан ч 2-р хавсралт эцэг эхийн зөвлөл байгуулах тухай зөвлөмжийг анзаарч үзээгүй, хэрэгжүүлээгүй байна.

- ХТҮЗ-ийн хавсралтуудыг авч ашигласан сургуулиуд ч байна. Гэхдээ өөрийн онцлогт тохируулаагүй, шууд хуулбарлан ашиглаж байна. Жишээлбэл:

3. Мэдээллийг хүлээн авах журмаа өөрийн сургуулийн онцлогт тохируулан нарийвчлан хийгээгүй, шинжлэн судлаагүй, хуулбарлан буулгасан учир хэрэгжих боломжгүй байна.

4. Үнэлгээнд хамрагдсан сургуулиуд эрсдэлийн үнэлгээ, бодит судалгаанд суурилан бодлогоо боловсруулаагүй, жишиг бодлогыг шууд хуулбарлан баталгаажуулсан байна. ХХБ-ын үндэслэл хэсэгт эрсдэлийн үнэлгээ, судалгааны үр дүнг тусган өөрийн онцлогт тохируулан нарийвчлан боловсруулсан нэг ч сургууль байгаагүй.
5. Үнэлгээнд хамрагдсан 5 сургуулиас бусдад нь хүүхэд хамгаалалтай холбоотой гарсан журмууд сургуулийн бусад баримт бичигтэй уялдаагүй, салангид хэлбэрээр байна.

#### Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт

Сургуулиуд ХХБ-оо сургуулийн онцлогт тохируулан боловсруулаагүй, боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэхэд олон талын бодитой оролцоог хангаагүй, сургуулийн бусад баримт бичигтэйгээ уялдуулаагүй нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Үүнд:

1. ХХБ сурталчлан таниулах үйл ажиллагаа хангалтгүйн улмаас ХХБ-ын хэрэгжилт хангагдаж чадахгүй байна.
2. Эрүүл аюулгүй орчин, дарамт, үл хайхрах зэрэг ойлголтын талаар багш, эцэг эх, хүүхдүүд дутуу ойлголттой байна. Багш, эцэг эх, хүүхдүүдийн асуулгад хариулсан байдлаас харахад дараах ойлголтууд дээр олон бөгөөд ижил хэмжээний санал өгсөн байна. Үүнд:
  - a. “Эрүүл аюулгүй орчин” гэдгийг сургуулийн гадаад болон дотоод материаллаг орчин гэж ойлгож байна.
  - b. “Үл хайхрах” гэдгийг тухайн хүүхэдтэй ярилцахгүй, тэднийг сонсохгүй, ойлгохгүй байх зэрэг хандлага гэж ойлгож байна.
  - c. “Дарамт” гэдгийг бие махбодод халдах болон нэр хоч өгөх, тохуурхах, шоглох гэж ойлгож байна.
3. Эрүүл аюулгүй орчны талаарх асуултад материаллаг орчинтой холбоотой хариултыг илүү сонгосон нь сургуулиудын материаллаг орчин тааруу байгааг илтгэж байна гэж үзэж байна.
4. Сургуульд ирж очих зам аюултай гэж багш, эцэг эх, суралцагчид үзэж байна.
5. Нүхэн жорлонг хэвийн, байдаг зүйл гэж талууд ойлгож байна. Нүхэн жорлонг асуудал гэж харахгүй харин “хаалгагүй”, “завсарлагаагаар дараалал их болдог” гэх мэт асуудлыг дурдсанаас энэ нь харагдаж байна.
6. Суралцагчдын хариултаас “сургууль, дотуур байранд хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж хүүхдийн эрхийг хангах” зорилтын хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэж болохоор байна. Жишээлбэл:
  - a. Хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголттой эсэхдээ 40% нь эргэлзэж

- байна
- b. Сургуулийн орчинд эрхээ хамгаалж чадах эсэхэд 3 хүүхэд тутмын 1 нь эргэлзэж байгаа бол 10% нь чадахгүй гэж хариулсан
  - c. Ковидын үед хичээлээ сайн хийж чадсан эсэхэд 3 хүүхэд тутмын 1 нь эргэлзэж байгаа бол 40% нь чадаагүй гэж хариулсан
  - d. Хичээлээ ойлгоогүй бол сэтгэлээр унадаг 60% гаруй нь хариулсан
  - e. 3 хүүхэд тутмын 1 нь сургууль нь аюулгүй орчин эсэхийг “сайн мэдэхгүй” харин 15% орчим нь “үгүй” гэж хариулсан
  - f. Сургууль дээр хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тухай айлгүй мэдээлж чадна гэж 3 хүүхэд тутмын 1 нь л үзэж байна
  - g. Багшийн хандлагатай холбоотой бүлэг асуултад 20-30% “сайн мэдэхгүй”, тал нь багшийн хандлагаас шалтгаалж хүүхэд хоорондын харилцаа өөрчлөгддөг, 4 хүүхэд тутмын 1 нь багшийн хандлагаас шалтгаалж хичээлдээ идэвхгүй болдог гэж үзэж байна.
7. Суралцагчид сургуулийн материаллаг орчныг сайжруулах, сургуулийн соёл буюу харилцаа, хандлагыг өөрчилж ялгаварлан гадуурхалт, дарамт хүчирхийллийг арилгах, сургалтын чанарыг дээшлүүлэх хүсэлтэй байна.
  8. Багш нар сургуулийн орчныг сайжруулж, дүрэм журам, хамт олны харилцаа хандлагыг өөрчлөх санал өгсөн байна
  9. Эцэг эхчүүд сургуулийн гадаад орчныг сайжруулж, эцэг эхчүүдэд хандсан сургалт, сурталчилгаа хийж тэдний оролцоог хангах талаарх ажил хийхийг санал болгосон байна.

#### Дотуур байр

1. Дотуур байрны асуудлыг ХХБ-д хэрхэн тусгасан талаар талуудын өгсөн хариулт зөрүүтэй бөгөөд баримтаар нотлогдоогүй
2. Сургуулийн ХХБ-доо дотуур байрны асуудлыг тусгасан ганцхан сургууль байна.
3. Цөөн тооны сургуулийн дотуур байрны багш суралцагчдаас санал авдаг сайн туршлага байна.
4. Дотуур байрны асуудлыг сургуулийн ХХБ-ын нэг хэсэг бус салангид байдлаар үзэж дотуур байрны багшид даатгаж байна. Сургуулийн захирал, нийгмийн ажилтан анхаарахгүй орхиж байна.
5. Дотуур байрны орчны талаарх асуулгад өгсөн суралцагчдын хариултаас үзэхэд дотуур байрны орчин, аюулгүй байдал хангалтгүй байна.
  - a. Гаднах гэрэлтүүлэг, камержуулалтгүй дотуур байр байсаар байна
  - b. Дотуур байрны орчин нөхцөлтэй холбоотой асуултаудад 3 хүүхэд

тутмын нэг нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн нь суралцагчид дотуур байрны орчин нөхцөл ямар байж болох талаар төсөөлөл байхгүй, одоогийн амьдарч буй нөхцөлөө үнэлж чадахгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

- c. Суралцагчдын 27% нь дотуур байранд амьдрах дургүй, талаас илүү хувь нь сандал ширээ тохиромжгүй, хүрэлцээгүй гэж хариулсан.
- d. Суралцагчид дотуур байрны багш нараас үл хайхрах, сэтгэл санааны дарамт болон бие махбодын шийтгэл илүү авдаг.

“Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл явцад оролцогч болон үр шим хүртэгч талууд сэтгэл ханамжтай байна уу?” гэсэн асуултын хүрээнд хийсэн шинжилгээгээр **“талуудын сэтгэл ханамжийн түвшин дундаж”** гэж дүгнэлээ.

- 1. Сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхчүүдийг хангалттай оролцуулдаггүй, оролцуулсан ч утга учиртай оролцоог хангаж чадахгүй байна.
  - a. Хүүхэд хамгааллын талаар сургуулиас зохион байгуулж буй үйл ажиллагаануудад эцэг эхчүүдийн 20% нь сэтгэл хангалуун байдаг.
  - b. 3 эцэг эхийн 1 нь сонирхолтой зохион байгуулбал оролцоно гэж хариулсан.
  - c. ХХБ-ыг боловсруулах, хэрэгжилтийг төлөвлөхдөө эцэг эхийн саналыг авдаггүйгээс ХХБ нь сургуулийн онцлогтоо тохироогүй.
- 2. Эцэг эхчүүдийн тал нь ХХБ-той болсноос хойш сургууль зарим талаараа сайжирсан гэж үзсэн, 3 эцэг эх тутмын нэг нь ямар ч өөрчлөлт гараагүй гэж үзсэн.
- 3. Суралцагчдын талаас илүү нь сургуулийн орчин, соёл, харилцаа хандлагад сэтгэл ханамжгүй байдаг гэж дүгнэж болохоор байна.





## ЗӨВЛӨМЖ

Сургуулийн ХХБ-ын хэрэгжилтэд хийсэн хөндлөнгийн үнэлгээний үр дүнд тулгуурлан холбогдох оролцогч талуудад хандан дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

### Засгийн Газарт

1. Үнэлгээнд хамрагдсан 2650 гаруй хүүхдээс ирсэн саналын 43% нь чөлөөт цагаараа олон талаар хөгжих хүсэлтэй байгаа талаар дурдсан. Тухайлбал: Хичээлийн бус цагаар сонирхсон хэл, урлаг, спортоор гүнзгийрүүлэн суралцах, хөгжих, урлаг спортын зааланд бэлтгэл хийх, тоглох боломжоор хангагдах, найзуудтайгаа хамтарч хичээлийн бус цагаар даалгавраа хийх, ярилцах өрөө, номын сан, кофе шоптой болох зэрэг хүсэлтийг ирүүлсэн байна. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 31-р зүйл “1. Оролцогч улсууд хүүхдийн амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, насныхаа онцлогт тохирсон тоглоом наадамд оролцох, соёлын амьдрал, урлан бүтээх үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох эрхийг хүлээн зөвшөөрнө. 2. Оролцогч улсууд нь соёлын болон уран бүтээлийн амьдралд бүрэн оролцох хүүхдийн эрхийг дэмжин хүндэтгэж, соёл, уран бүтээл, амралт, чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцох зохистой болон тэгш бололцоо олгоход дөхөмж үзүүлнэ” гэж заасан байдаг. Энэ конвенцийн хэрэгжилтийг хангах нь ЗГ-н үүрэг учир хүүхдүүд чөлөөт цагаа өнгөрөөх, хичээл сургуулиас гадуур хөгжих орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах.

### Боловсрол Шинжлэх Ухааны Яаманд

1. ЕБС-д Хүүхэд хамгааллын аль жишиг бодлогыг баримтлахыг тодорхой болгох, эсвэл нэгтгэж нэг жишиг гаргаж мөрдүүлэх
2. БШУЯ-аас гарч буй бодлогыг хэрхэн цогцоор хэрэгжүүлэх талаар нэгдсэн зааварчилгаа, ойлголт өгөх ажлыг зохион байгуулах.
3. ХХБ-той холбоотой ойлголтуудыг тодорхой болгох. Жишээлбэл: Хүүхдийн эрх, эрүүл, аюулгүй орчин, дарамт, үл хайхрах гэх мэт. Оролцогчдын хариултаас үзэхэд дараах асуудал дээр анхаарах шаардлагатай байна.
  - a. Эрүүл аюулгүй орчны хүрээнд
    - i. Шим тэжээлтэй, биед сайн хоолтой, хүүхэд өлсөж цангахгүй байх
    - ii. Цэвэрхэн, тухтай ариун цэврийн өрөөтэй байх
    - iii. Хичээлээс гадна урлаг, спортын авьяас чадвараа хөгжүүлэх боломж нөхцөлөөр хангагдах
  - b. Үл хайхрахын хүрээнд
    - i. Өлсөх, даарах халууцах зэрэг гадны нөхцөлөөс болж хичээлдээ

төвлөрч чадахгүй, суралцах орчин бүрдэхгүй байх.

4. “Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй, материаллаг болон нийгэм, сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлэх” зорилтод хүрсэн эсэхийг хэрхэн хэмжихээ тодорхой болгох.
5. ХХБ, хэрэгжүүлэх төлөвлөгөөг сургуулийн онцлогт тохируулан олон талын оролцоотойгоор боловсруулах заавар, зөвлөмжөөр хангах.
6. ХХБ-ын хэрэгжилтийн тайланг бодлогод заасан дагуу авч, дүн шинжилгээ хийж зөвлөмж гаргаж хүргүүлэх – сургууль-БГ/БХ-БШУЯ, цаглабар гаргах
7. Дүн шинжилгээний үр дүн, зөвлөмжийг олон талын оролцоотой хэлэлцүүлэх ажлыг тогтмол хийх
8. Сургуулийн орчны стандартыг мөрдүүлэх
9. Сургуулиудын хүчин чадал, багтаамж, бүлэг дүүргэлт, ээлжийн коэффициентыг тогтоосон хязгаарт байлгахад анхаарах, энэ нь хичээлээс гадуурх үйл ажиллагааг сургууль дээр зохион байгуулах боломжийг олгоно.

### **Боловсролын Ерөнхий Газарт**

1. Сургуулийн соёл болж хэвшсэн “дүрэм”-ийг хүний эрхийн өнцгөөр харж шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх. Тухайлбал: Суралцагчдын үс засалт, хувцаслалтад тогтоосон “стандарт”, гадаа жагсааж байж сургууль руу оруулах, хичээлийн бус цагаар сургууль дээр байхыг хориглох, охидын үзлэг гэх мэт.

### **Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар болон дүүргийн боловсролын хэлтэст**

1. ХХБ боловсруулахад, ялангуяа өөрийн сургуулийн онцлогт тохирсон, талуудын бодит оролцоог хангасан байдлаар боловсруулж хэрэгжүүлэхэд сургуулиудад арга зүйн дэмжлэг үзүүлэх
2. ХХБ-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг А/476 тоот тушаалд заасны дагуу эцэг эхийн оролцоотой зохион байгуулж тайланд дүн шинжилгээ хийж сургуулиудад зөвлөмж хүргүүлэх.

### **Ерөнхий боловсролын сургуулиудад**

1. ХХБ-ыг өөрийн сургуулийн онцлогт тохируулан боловсруулах, ингэхдээ эцэг эх, суралцагч зэрэг хамааралтай талуудын бодитой оролцоог хангах. Жишээлбэл: Эрсдэлийн үнэлгээ хийх, үр дүнг нь ХХБ-ын үндэслэл хэсэгт тусгах, хэрэгжүүлэх механизмыг нарийвчлан тодорхойлох гэх мэт.
2. ХХБ-ыг нийт эцэг эх, суралцагчдад ойлгомжтой хэлбэрээр танилцуулах, хүүхэд хамгааллын хүрээнд сургалт, таниулах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулж

---

ХЭВШИХ.

3. Бодлогын баримт бичгийн уялдааг хангах Жишээ нь:
- i. Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журамд ажлын хэсэг байгуулах тухай гэдэгт ХХБ аа оруулах , сахилга хариуцлага хэсэгт ХХБ-ын хэрэгжилтийг хангаагүй бол ямар хариуцлага хүлээхийг, Сайн ажиллаж байгаа бол хэрхэн арга туршлагыг нь түгээхийг
  - ii. Хөдөлмөрийн гэрээнд: Багш нартай хийх гэрээнд хүүхэд хамгааллын бодлогыг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллахыг ажлын үзүүлэлт болгох
  - iii. Сургууль хөгжүүлэх хөтөлбөрт “Сургууль хүүхдэд ээлтэй сайн сургууль” болоход шаардлагатай ажлуудыг цогцоор төлөвлөх
  - iv. Сургуулийн стратеги төлөвлөгөөнд : Үе тэнгийн дарамт дээрэлхэлтийг бууруулж хүчирхийлэлгүй “хүүхдэд ээлтэй” болох зорилтыг дэвшүүлэх
  - v. Сургалтын бодлого Хүүхдэд ямар сургалтыг нэмэлтээр орох, эцэг эхэд ямар сургалтаар нөлөөлөл хийх, багшийн хөгжлийн хөтөлбөрт жендэрийн тэгш байдлыг хангах сургалтаа холбон оруулах, тусгайлан гаргаж байгаа Багшийн хөгжлийн хөтөлбөрт хүүхдийн хэрэгцээнд суурилсан тэгш хүртээмжтэй боловсрол олгох, хүүхдийн эрх хамгааллын бодлогоо уялдуулах
  - vi. Архив, албан хэргийн хөтлөлт, хадгалалтын журамд: Кейсийн баримтжуулалтын хадгалалт хамгааллыг оруулах гэх мэт
4. ХХБ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөөг жил бүр боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ХХБ-д заасны дагуу төсөвт тусгах, зориулалтын дагуу зарцуулж, хэрэгжилтийн тайланг сургуулийн зөвлөл, хамт олонд тогтмол тайлагнах, зөвлөмжийг хэрэгжүүлэх

## ХАВСРАЛТ

### **БШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газраас 2018 онд боловсруулан гаргасан дүрэм журам, бодлогын баримт бичгүүд:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний жишиг шаардлага, үлгэрчилсэн загвар, хэрэглэх зөвлөмж 2018 оны 03 дугаар сарын 29. **А/155**
2. “Бага, суурь бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах журам” 2018 оны 04 дүгээр сарын 03 **А/168**
3. “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөр 2018 оны 4 дүгээр сарын 06 **А/181**
4. “Боловсролын байгууллагын сургалтын орчин ба дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам” 2018 оны 05 дугаар сарын 01 **А/239**
5. “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм” 2018 оны 05 дугаар сарын 01 **А/243**
6. “Сургуулийн аюулгүй орчныг бүрдүүлэх дунд хугацааны төлөвлөгөө” 2018 оны 6 дугаар сарын 22 **А/398**
7. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр 2018 оны 7 дугаар сарын 30 **А/467**
8. “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь ХХБ” 2018 оны 7 дугаар сарын 31 **А/476**
9. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам 2018 оны 10 дугаар сарын 1 **А/612**

### **Засгийн газрын бусад гишүүдтэй хамтран баталсан тушаал**

10. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай”
11. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар коммисын шийдвэрийн маягт, хүүхдийн хувийн хэрэг хөтлөх маягт, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэлийн маягт батлах тухай” 12. Үлгэрчилсэн загвар, жагсаалт батлах тухай “Хүүхдийн цэцэрлэгийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар, ерөнхий боловсролын сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчийн ажлыг байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрүүл мэндийн кабинетэд

---

байх шаардлагатай эм, багаж хэрэгслийн жагсаалт”

12. ЕБС-ийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлан үлгэрчилсэн чиглэл А\119
13. Монгол Улсын стандарт “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал” Ерөнхий шаардлага MNS6782:2019
14. Монгол Улсын стандарт “ЕБС-ийн суралцагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ” Ерөнхий шаардлага MNS6781:2019
15. Монгол улсын стандарт “Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага” Ерөнхий шаардлага” MNS6799:2019
16. ЕБС-ийн үлгэрчилсэн дүрэм 2010 он
17. Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх журам 2019.12.17 А\803
18. МУХНХСайдын 2020.01.28 дугаар 01 Хүүхдийн эрхийг хамгаалах эрсдлээс урьдчилан сэргийлэх тухай албан даалгавар

